

Гарчиг

1	Хамрах хүрээ	5
2	Норматив эшлэл.....	6
3	Нэр томьёо, тодорхойлолт	7
3.1	Алсын радио нэгж – (RRU).....	7
3.2	Үндсэн зурвасын нэгж– (BBU).....	8
4	АЛСЫН РАДИО НЭГЖ (RRU).....	8
4.1	RRU-ийн үндсэн тодорхойлолт.....	8
4.2	RRU-ийн функцүүд.....	8
4.3	RRU-ийн техник хангамж.....	8
5	5G RRU ТУРШИЛТ, ХЭМЖИЛТИЙН АРГАЧЛАЛ.....	10
5.1	Хэмжилт туршилтад бэлтгэх дараалал.....	12
5.1.1	Бэлтгэл ба тохируулга	12
5.1.2	RRU болон хэмжилтийн орчны тохиргоо.....	12
5.1.3	Гүйцэтгэлийн хэмжилт	12
5.1.4	Хөдлөмжийн хэмжилт	13
5.1.5	Ачааллын хэмжилт.....	13
5.1.6	Дулааны болон хүрээлэн буй орчны хэмжилт.....	13
5.1.7	Гэмтэл болон сэргээх хэмжилт.....	13
5.1.8	Баримтжуулалт ба үр дүн	13
5.1.9	Нийцлийн шалгалт	13
6	5G RRU SUB-6ГГЦ ХЭМЖИЛТИЙН АРГА	14
6.1	А ангиллын тоног төхөөрөмжийн хэмжилтийн арга.....	14
6.1.1	5G RRU – Жигд цацаргалттай эквивалент чадлын (Pe.i.r. p) тооцоолол	15
6.1.2	5G RRU – Цацраг хэлбэржүүлэлт болон цацаргалтын графикууд	16
6.2	Давтамжийн муж	17
6.3	5G RRU-ийн цацаргалтыг хэмжих.....	19
6.4	Зөвшөөрөгдөөгүй (Unwanted Emission) цацаргалтын хэмжилтийн арга	20
6.4.1	5G RRU-ийн нийт цацаргалтын (Total Emissions TE) хэмжилт.....	20
6.4.2	5G RRU-ийн бусад цацаргалтын (OE) хэмжилт	21
6.5	Нийт цацаргалтын (TE) хэмжилтийн арга	21
6.5.1	5G RRU талбайн хэмжилтийн тайлангийн загвар.....	25
6.6	Хэмжих 5G RRU хүлээн авагчийн шаардлагууд.....	26
6.6.1	5G RRU eirp хэмжилт	27

6.6.2 Бусад цацаргалтыг (OE) хэмжих арга	29
6.6.3 Төхөөрөмжийн ангилал, түүний хязгаарууд	30
6.6.4 Бусад цацаргалт (OE)	31
6.6.5 Нийт чадлын спектр нягт (UE-TP)	32
7 ЦУУРАЙГҮЙ КАМЕР БУЮУ ЧЕМБЕРИЙН ӨРӨӨНД 5G RRU ХЭМЖИЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ	33
7.1 5G RRU хамгийн их дамжуулах чадамжийг (5G RRU Throughput Testing Plan) хэмжих	33
7.2 5G RRU лабораторийн хэмжилтийн тайлан загвар.....	35
7.3 5G RRU нэвтрүүлэгчийн асаах / унтраах (on/off) үеийн чадлын хэмжилт	35
7.4 5G RRU-ийн нэвтрүүлж буй дохионы чанарыг хэмжих	36
7.4.1. Хүлээн авсан дохионы лавлагаа дохио (RSRP), хүлээн авсан дохионы чанарын лавлагаа (RSRQ), дохио шуугиан, интерференцийн харьцаа (SINR) хэмжих.....	37
7.5 EVM хэмжих модуляцийн чанарын сорилт:	37
7.6 Spectrum Emission Mask (SEM) болон (Adjacent Channel Leakage Ratio - ACLR) шалгах.....	37
7.6.1 SEM болон ACLR хэмжих арга:	37
7.6.2 Тайлангийн загвар (Жишээ):	38
7.7 Динамик царааг тодорхойлох:	38
7.8 5G RRU-ийн нэвтрүүлэх дохионы чанар	39
7.9 Спектрийн хэтрэлтийн хязгаарыг тодорхойлох Хэмжилтийн аргачлал:	40
7.10 5G RRU-ийн зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE).....	43
7.11 Хуурамч цацаргалт (SE)	45
7.12 Интермодуляц.....	46
7.13 5G RRU-ийн түлхүүр RF үзүүлэлтүүдийг цуурайгүй камер буюу радио долгионы нөлөөллөөс бүрэн тусгаарлагдсан орчин буюу чемберт хэмжих	47
7.14 ЦУУРАЙГҮЙ ЧЕМБЕРТ ХИЙХ 5G RRU ХЭМЖИЛТ	50
ХАВСРАЛТ 1	53
1. Төвлөрсөн ба виртуал Радио хандалтын сүлжээ (PXC)	53
2. C-RAN	53
3. Виртуал Радио хандалтын сүлжээ V-RAN	54
4. gNB (CU/DU) ба RRU / Remote Radio Head (RRH) хоорондын интерфэйс	55
“RRU-д дотоод дохио дамжуулах холбоо, бага хоцролт, зурвасын өргөн их, бодит хугацааны дохио боловсруулалт шаардагдана.	55
X.1.1 RRU суурилуулах интерфэйс ба жишээ	56
X.1.2 RRU Хажуу байрлалд суурилуулсан интерфэйс.....	57
X.1.3 RRU-ын өгөгдлийн холболт	58

ХАВСРАЛТ 2	62
Х.2.1 RRU суурилуулалт	63
Х.2.2 Цахилгаан тэжээлийн хангамж	65
Х.2.3 Төвлөрсөн газруудаас авах тогтмол гүйдлийн тэжээл	66
ХАВСРАЛТ 3 ЦУУРАЙГҮЙ ЧЕМБЕР	69
Х.3.1 Цуурайгүй Чемберийн Хэмжилтийн орчин ба ерөнхий зохицуулалт	69
Х.3.2 Газардуулгын дамжуулагч хавтгайтай чембер	70
Х.3.3 Антену хэмжилт	71
Х.3.4 Антену хэмжилт	72
Х.3.5 Сайтын цацаргалтыг хэмжих зөвлөмж	72
Х.3.5.1 Хэмжилтийн талбайн баталгаажуулалт	72
Х.3.5.2 DUT-ийг бэлтгэх	72
Х.3.5.3 DUT тэжээлийн хангамж	73
Х.3.5.4 Хамрах хүрээний урт	73
Х.3.5.5 Сайтын бэлтгэл	73
Х.3.5.6 RF кабелийн ерөнхий шаардлага	74
Х.3.5.7 Дизайны норматив шаардлага	74
Х.3.5.8 Хэмжилтийн антен ба урьдчилсан өсгөгчийн үзүүлэлтүүд	75
Х.3.6 Төлөөлөл болгосон хананы тодорхойлолт	75
Х.3.7 Хананы унтралтыг хэмжих журам	76
Х.3.8 Ердийн хананы хэмжилтийн үр дүн	77
Х.3.9 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ, ХЭМЖИЛТИЙН ЖУРАМ	77
Х.3.10 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ	78
Х.3.10.1 БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭМЖИЛТИЙН АРГАЧЛАЛ	78
Х.3.10.2 Хэмжилтийн горимын шаардлага	78
Х.3.10.3 Техникийн шаардлага	79
Х.3.11 Ерөнхий радио параметрийн шаардлагууд:	80
Х.3.12 RRU ТӨХӨӨРӨМЖИЙН СОРИЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	82
Х.3.13 АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА	83
Х.3.14. RRU Хэмжилтийн систем ба арга	84
ХАВСРАЛТ 4	88
Х.4.1 Хэмжилт, хэмжилтийн аргачлал	88
Х.4.2 5G RRU – Төхөөрөмжийн Сорилтийн Ерөнхий Шаардлага	89
Х.4.3 ОТА ба Beamforming хэмжилт	90
Х.4.4 Хэмжилтийн орчны нөхцөл	90

Х.4.5 Ашиглах стандартууд	90
Х.4.6 RRU Хэмжилтийн Систем ба Арга	90
Х.4.6.1 Хэмжилтийн системийн бүрдэл хэсгүүд	90
Х.4.6.2 Хэмжилтийн аргачлал	91
Х.4.7 RRU Төхөөрөмжийн Дотоод Архитектур (Блок схем)	91
Х.4.8 RRU блок диаграммд суурилсан хэмжилтийн аргачлал.....	91
Х.4.8.1 CPU ба Удирдлагын хэсэг	91
Х.4.8.2 FPGA – Өгөгдөл боловсруулах хэсэг.....	91
Х.4.8.3 RF Интерфейс – DL/UL/OPT	91
Х.4.8.4 Хэмжилт хийх дараалал	92
Х.4.9 RRU хэмжилтийн гаднах системийн холболтын схем	92
Х.4.9.1 Системийн бүрэлдэхүүн хэсгүүд.....	92
Х.4.10 RRU хэмжилтийн алхам бүрийн тайлбартай шалгах хуудас.....	94
Мэдээллийн товчилсон хураангуй.	104
НОМ ЗҮЙ.....	109

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Хөдөлгөөнт холбооны “5G Алсын радио нэгж (RRU)”, Алсын радио нэгжийн хэмжилтийн аргачлал	MNS
Methodology of measurement in Mobile communication radio unit "5G Remote Radio Unit (RRU)	MNS

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны.. дүгээр сарын -ний өдрийн С/ дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2025 оны дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Монгол улсад өнөөгийн нөхцөлд хөдөлгөөнт холбооны 4G LTE-д суурилсан 5G сүлжээг нэвтрүүлэхэд зайлшгүй шаардлагатай төхөөрөмжийн нэг нь Алсын радио нэгж (5G RRU) юм.

Үүрэн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ явуулж байгаа оператор компаниудын бааз станцад 4G-ээс 5G сүлжээнд шилжихэд тэдгээрийн төрөл, ангилал, үйлдвэрлэгчийн болон техникийн үзүүлэлтүүдийг хэмжиж баталгаажуулахад уг стандартыг хэрэгжүүлнэ.

Энэ стандарт нь 4G сүлжээнд 5G үйлчилгээг нэвтрүүлэхэд үүр хоорондын харилцан нөлөөллийг бууруулахад чиглэгдэнэ.

Алсын радио нэгж (RRU) нь гар утас, хөдөлгөөнт төгсгөлийн төхөөрөмж зэрэг хэрэглэгчийн төхөөрөмжийн (UE) тусламжтайгаар бүхий л операторын сүлжээнд холбогддог тархмал байрлалтай, нэгдсэн давтамж бүхий нэгж юм.

Уламжлалт үүрэн хөдөлгөөнт холбооны системд зориулсан радио бүтэц нь ихэвчлэн дотор орчны бие даасан дан системд буюу бааз станцад суурилдаг бол 5G үүрэн холбооны бүтэц нь "тархмал ба нэгдмэл" гэсэн логик нэр томъёололтой. Иймд BTS (Бааз терминал станц) нь BBU, Алсын радио нэгж (RRU) зэрэг радио нэгжүүдийн нэгтгэл юм. Уг радио нэгжүүдийг антены цамхаг дээр эсвэл гэрлийн баганад суурилуулна.

3GPP суурь стандартын үүрэн хөдөлгөөнт холбооны 4G-ээс 5G нэвтрүүлэх үе шатанд 5G алсын радио нэгжийг (RRU) нэвтрүүлэх үүрүүдийн тоо, хэмжээ болон хамрах хүрээнээс хамааран олон тоогоор ашиглах хэрэгцээ шаардлагын дагуу тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүдийг хэмжих, зөвшөөрөгдөх стандартын утгатай харьцуулан баталгаажуулах хэрэгцээ, шаардлага үүсэх бөгөөд энэ нь харилцан нөлөөллийг бууруулах үндсэн нөхцөлийн нэг болно.

Энэ стандарт нь 5G алсын радио удирдлагатай нэгжийг (RRU) шинээр нэвтрүүлэх, төлөвлөх, өргөтгөхөд техникийн болон суурилуулалтын хамгийн бага шаардлагыг тодорхойлно.

Энэ стандартыг хөдөлгөөнт холбооны сүлжээг байгуулахад, түүний ашиглалт үйлчилгээг явуулах оператор компаниуд уг үйлчилгээ явуулах бусад цацаргалт аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн инженер техникийн ажилтнууд, зураг төсөл зохиогч болон төслийн байгууллага мөрдөнө.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ.

[1] ETSI TS 132 450 V13.0.0 (2016-02), Technical specification: Universal Mobile Telecommunications System (UMTS); LTE; Telecommunication management; Key Performance Indicators (KPI) for Evolved Universal Terrestrial Radio Access Network (E-UTRAN): Definitions (3GPP TS 32.450 version 13.0.0 Release 13)

[2] [http://Project%20RF%20antenna/Алсын радио нээж \(RRU\)%20standard/Алсын радио нээж \(RRU\)-Remote%20Radio%20Unit_%20Function,Concept,Details%20-%20Telecomkhabar.html](http://Project%20RF%20antenna/Алсын%20радио%20нээж%20(RRU)%20standard/Алсын%20радио%20нээж%20(RRU)-Remote%20Radio%20Unit_%20Function,Concept,Details%20-%20Telecomkhabar.html)

[3]<http://www.morelinktec.cpm/news/what-is-the-difference-between-5G-base-station-system-and-4G>

[4] ETSI TS 110 174-2-2 V1.2.1 (2020-11) Chapter 6 - RRU Infrastructure, Technical specification: "Access, Terminals, Transmission and Multiplexing (ATTM); Sustainable Digital Multiservice Communities; Broadband Deployment and Energy Management; Part 2: Multiservice Networking Infrastructure and Associated Street Furniture; Sub-part 2: The use of lamp-posts for hosting sensing devices and 5G networking".

[5] ETSI EN 300 113 V2.1.1 (2016-08), Harmonised European Standard: "Land Mobile Service; Radio equipment intended for the transmission of data (and/or speech) using constant or non-constant envelope modulation and having an antenna connector; Harmonised Standard covering the essential requirements of article 3.2 of the Directive 2014/53/EU".

[6] ETSI TS 138 141-1 V15.3.0 (2019-10), Technical specification: "5G; NR; Base Station (BS) conformance testing Part 1: Conducted conformance testing (3GPP TS 38.141-1 version 15.3.0 Release 15)".

[7] ETSI EN 302 498-1 V1.1.1 (2009-08) Annex A.1 - Chamber, European Standard: "Electromagnetic compatibility and Radio spectrum Matters (ERM); Short Range Devices (SRD); Technical characteristics for SRD equipment using Ultra WideBand technology (UWB); Object Discrimination and Characterization Applications for power tool devices operating in the frequency band from 2,2 GHz to 8,5 GHz; Part 1: Technical characteristics and test methods".

[8] CISPR 16-1 (2003): Specification for radio disturbance and immunity measuring apparatus and methods - Part 1: "Radio disturbance and immunity measuring apparatus".

[9] ETSI TR 100 028 (all parts) (V1.4.1), Technical Report: "Electromagnetic compatibility and Radio spectrum Matters (ERM); Uncertainties in the measurement of mobile radio equipment characteristics".

[10] ETSI TR 102 273 (all parts) (V1.2.1), Technical Report: "Electromagnetic compatibility and Radio spectrum Matters (ERM); Improvement on Radiated Methods of Measurement (using test site) and evaluation of the corresponding measurement uncertainties".

[11] ANSI C63.5 (2006): "American National Standard for Calibration of Antennas Used for Radiated Emission Measurements in Electromagnetic Interference (EMI)". ECC Decision of 30 March 2007 on specific Material Sensing devices using Ultra Wideband (UWB) technology (ECC/DEC/(07)01), amended 26 June 2009

[12] [https://www.etsi.org/standards#page=1&search=5G%20АЛСЫН РАДИО НЭГЖ \(RRU\)&title=1&etsiNumber=1&content=1&version=0&onApproval=1&published=1&withdrawn=1&historical=1&isCurrent=1&superseded=1&startDate=1988-01-15&endDate=2025-04-13&harmonized=0&keyword=&TB=&stdType=&frequency=&mandate=&collection=&sort=1](https://www.etsi.org/standards#page=1&search=5G%20АЛСЫН РАДИО НЭГЖ (RRU)&title=1&etsiNumber=1&content=1&version=0&onApproval=1&published=1&withdrawn=1&historical=1&isCurrent=1&superseded=1&startDate=1988-01-15&endDate=2025-04-13&harmonized=0&keyword=&TB=&stdType=&frequency=&mandate=&collection=&sort=1)

[13] ETSI TS 128 552 V18.10.0 (2025-04), Technical specification: 5G; Management and orchestration; 5G performance measurements (3GPP TS 28.552 version 18.10.0 Release 18)

[14] ETSI TS 138 521-3 V15.2.0 (2019-05), Technical specification: 5G; NR; User Equipment (UE) conformance specification; Radio transmission and reception; Part 3: Range 1 and Range 2 Interworking operation with other radios (3GPP TS 38.521-3 version 15.2.0 Release 15)

[15] ETSI TS 138 104 V17.5.0 (2022-04), Technical specification: 5G; NR; Base Station (BS) radio transmission and reception (3GPP TS 38.104 version 17.5.0 Release 17)

[16] ETSI TS 138 141-1 V17.5.0 (2022-04), Technical specification: 5G; NR; Base Station (BS) conformance testing Part 1: Conducted conformance testing (3GPP TS 38.141-1 version 17.5.0 Release 17)

[17] ETSI EN 301 489-50 V2.4.0 (2025-06), Harmonised European Standard: ElectroMagnetic Compatibility (EMC) standard for radio equipment and services; Part 50: Specific conditions for Cellular Communication Base Station (BS), repeater and ancillary equipment; Harmonised Standard for ElectroMagnetic Compatibility

[18] 3GPP TS 38.101-1, Technical specification: NR; User Equipment (UE) radio transmission and reception; Part 1: Range 1 Standalone, Release 15

[19] ХХЗХ-ны 2023.09.13 өдрийн “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай №106 тогтоол

[20] ITU-R M.2150-2, Recommendation: M Series: Mobile, radiodetermination, amateur and related satellite services, Detailed specifications of the terrestrial radio interfaces of International Mobile Telecommunications-2020 (IMT-2020)

ETSI / ITU-R-ийн холбогдох стандартууд:

5G RRU-ийн хэмжилттэй холбоотой дараах стандартуудыг ашиглана:

- ETSI TS 128 552: 5G сүлжээний гүйцэтгэлийн хэмжилтийн шаардлагуудыг тодорхойлсон стандарт. [13]
- ETSI TS 138 104: 5G NR суурь станцын тохиргоо болон хэмжилтийн шаардлагуудыг агуулсан стандарт. [15]
- ITU-R M.2150: IMT-2020 (5G)-ийн радио интерфэйсийн дэлгэрэнгүй техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон стандарт. [20]

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 Алсын радио нэгж – (RRU)

Энэ нь 4G LTE eNB-ын антены дор байрлах 5G үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах төхөөрөмж болно.

3.2 Үндсэн зурвасын нэгж– (BBU)

Үндсэн зурвасын нэгж (Base Band Unit, BBU)-ийн бүтэц, зохион байгуулалт нь үйлдвэрлэгч бүрийн хувьд бага зэрэг ялгаатай боловч бүгд 3GPP 5G стандартад нийцсэн байдаг. Уламжлалт үндсэн зурвасын нэгж BBU нь цамхгийн доод хэсэгт байрлах бааз станцын кабинет дотор тус тусдаа байрладаг байсан бол 5G сүлжээнд эдгээр үндсэн зурвасын нэгжүүд нь нэг BBU нэгжид төвлөрснөөр системийг илүү төвөгтэй болгосон ч илүү үр ашигтай, хэмнэлттэй болгож, үүнтэй холбоотой хурдны асар их давуу талтай болсон. Алсын радио нэгжээс (RRU) ирсэн шилэн кабелийн дохиог BBU дээр цахилгаан дохио болгон хувиргаж, үндсэн зурвасын давтамжийг тохируулсны дараа үндсэн сүлжээнд дамжуулал хийгдэнэ.

4 АЛСЫН РАДИО НЭГЖ (RRU)

4.1 RRU-ийн үндсэн тодорхойлолт

RRU-ийн үндсэн үзүүлэлт:

- RF антены коннектор дээрх хамгийн их гаралтын чадал (Maximum output power at RF antenna connector)
- RF антены коннектор дээрх хуурамч цацагралт (Spurious emissions at RF antenna connector)
- Цацаргасан хуурамч цацагралт (Radiated spurious emissions)
- Давтамжийн тогтворжилт (Frequency stability)
- Эзлэгдсэн зурвасын өргөн (Occupied bandwidth RSS-Gen)
- Хүлээн авагчийн хамаарагдах хязгаар (Receiver conducted limits).

RRU нь RBS-ийн үйлчлэх хүрээг алсаас 10 км хүртэл сунгадаг. Иймд антены ойролцоо байрлуулах зориулалттай. Шилэн кабель нь алсын радио нэгжийг (RRU) RBS үндсэн нэгж эсвэл өргөтгөсөн макро RBS-тэй холбоно. Алсын радио нэгжүүдийг (RRU) каскадын тохиргоонд болон оптикийн тусламжтайгаар од тохиргоонд холбож болно. RRU нь зөвхөн босоо бэхэлгээнд зориулагдсан.

4.2 RRU-ийн функцүүд

1. RRU нь нэвтрүүлэгч болон хүлээн авагчийн үүрэг гүйцэтгэнэ: Хэрэглэгчийн дохиог бааз станц руу дамжуулах, хүлээн авах ба эсрэг чиглэлд гүйцэтгэх.
2. Чадал, хоцролт зэрэг хэрэглэгчийн төхөөрөмжийн хооронд дэс дараалан дэмжлэг үзүүлж, холболтыг хангах.
3. Оптик ба цахилгаан соронзон хоёр физик шугамын хоорондох интерфэйсийг хангах.
4. Алсын цахилгаан хазайлтыг (RET) тохируулахад зориулсан алсын удирдлагын нэгж (RCU) зэрэг туслах төхөөрөмжийг дэмжих.
5. VSWR (Voltage Standing Wave Ratio), RET (Remote Electrical Tilt), (ACT) зэрэг ялгаатай дохионуудыг үүсгэж, илгээх.

4.3 RRU-ийн техник хангамж

RRU-ийн өөр өөр зориулалттай түгээмэл портуудыг нэгтгэн харуулав.

1. CPRI порт: CPRI0 ба CPRI1 гэсэн 2 порт байх ба зарим загварт нэг байж болно. Үндсэн үүрэг нь BBU-д холбогдох

2. RF порт: Үүнийг Jumper порт гэнэ. Хамгийн багадаа 2 холбогч порт байх ба тэдгээрийн нэг нь нэвтрүүлэх (Tx), нөгөө нь Нэвтрүүлэх/Хүлээн авах (Tx/Rx) үүрэгтэй. RF порт нь холбогч кабелиар антентай холбогдоно.
3. RET порт: Алсын удирдлагын нэгжтэй RCU холбоход хамгийн багадаа нэг RET порт байна. Ихэнх тохиолдолд холбогч нь ДБ9 байдаг боловч бусад цацаргалт тохиолдолд өөр өөр байж болно. RCU нь антентай холбогдсон. RET кабель нь RCU болон RRU-г холбодог.

RRU нь нээлттэй радио хандалтын сүлжээг (OpenRAN) үүсгэхэд чиглэсэн хос зурвастай.

Энэхүү загвар нь нээлттэй радио хандалтын сүлжээнд чадлын хоёр зурвасын радио нэгжүүд бүхий цахилгаан болон механик асуудлыг шийдвэрлэх шийдлүүдтэй. Тоон урьдчилсан гажуудал (DPD) болон крест фактор бууруулалт (CFR) нь долгионы хэлбэрийн чадлын харьцааг өндөр утгаас дундаж руу бууруулах аргууд юм. Эдгээр дохио боловсруулах нарийн төвөгтэй алгоритмуудтай холбоотойгоор одоогийн зах зээлийн бүтээгдэхүүнээс илүү сайн үзүүлэлттэй болсон.

Алсын радио нэгжийг (RRU) модуль бүтэцтэй болгосон. Модульчлагдсан бүтэц нь радио нэгжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг өсгөгч, тэжээлийн хэсэг болон бусад цацаргалт хэсгүүдтэй нэгтгэх боломжтой, олон төрлийн радио нэгжийг дахин холбох уян хатан байдлыг хангадаг.

1. Цахилгаан хангамжийн порт

Алсын радио нэгжийг (RRU) цахилгаан тэжээлийн нэг порттой. Ихэнхдээ хөх, хар өнгө бүхий кабелиуд байх ба хөх нь сөрөг (-), хар нь тэг (0) гэсэн утгатай. RRU нь -48В -д ажиллана.

2. Газардуулгын порт

Газардуулга хийх хоёр ОТ порт байдаг. *ОТ терминал (OT Lug / OT Connector / OT Terminal Lug) нь кабелийн үзүүрт шахаж бэхэлдэг төгсгөөч юм. “О” нь цагариг хэлбэртэй толгойг заах ба харин “Т” нь Tube буюу кабелийг хийж шахах хоолой хэсгийг заадаг. ОТ терминалыг кабелийн үзүүрт тусгай шахагч багаж (crimping tool) ашиглан тогтооно. Ингэснээр кабель ба RRU дээрх боолт хооронд бат бөх, найдвартай холболт үүсдэг. Давуу тал нь: Бэхэлгээ бат бөх, удаан хугацаанд сулардаггүй. Зэврэлтээс хамгаалах бүрээстэй байдаг (цайрдсан, зэс, эсвэл никель бүрмэл) RRU-ийн газардуулгын боолт дээр найдвартай холбогдоно* Газардуулгын кабель: ихэвчлэн зэс утас, нэг төгсгөл нь RRU-д, нөгөө төгсгөл нь RRU-ийн ойролцоох газардуулгын шин "Bus Bar" руу холбогдоно. Ихэвчлэн газардуулгын шин нь зэс эсвэл хөнгөн цагаан материалаар хийгдсэн байдаг. RRU-ийн газардуулгын ОТ кабель нь RRU-ээс гарч Bus Bar дээр холбогддог. Тэндээсээ бүх газардуулга нэгтгэгдэж, эцэстээ газардуулгын систем (earth pit, grounding system) рүү холбогдоно.

Олон төхөөрөмжийг нэг цэг дээр төвлөрүүлэн газардуулах, гүйдэл жигд тархах болон хяналт, засвар үйлчилгээ хийхэд хялбар байдгаараа давуутай. Холболтын зургийг 4.3-р зурагт үзүүлэв.



Зураг 4.3 RRU-ийн газардуулгын ОТ холболтын схем

3. RRU инновац ба үйлдвэрлэгчид

Сүүлийн жилүүдэд харилцаа холбооны тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид радио алсын удирдлагын нэгжийн (RRU) загвар, бүтцэд тогтмол шинэчлэл хийсээр байна. Инновацын үр дүнд RRU нь хөнгөн жинтэй, бат бөх, уян хатан хийцтэй болсон төдийгүй, ихээхэн багтаамжтай, олон зурвасыг нэг төхөөрөмжөөр зэрэг дэмжих боломжтой болсон. Өмнө нь нэг RRU зөвхөн нэг зурвасын дохиог боловсруулдаг байсан бол одоо нэгж нь жишээлбэл 2100 МГц-ийн хоёр болон түүнээс дээш зурвасыг нэгэн зэрэг дэмжих чадвартай болсон. Энэ өөрчлөлт нь нийт тоног төхөөрөмжийн өртгийг бууруулж, системийн найдвартай ажиллагааг нэмэгдүүлэн, суурилуулалт, ашиглалтын үр ашгийг мэдэгдэхүйц сайжруулж байна.

5 5G RRU ТУРШИЛТ, ХЭМЖИЛТИЙН АРГАЧЛАЛ

5G RRU-ийн хэмжилтийн аргачлал нь 5G сүлжээн дэх RRU-ийн гүйцэтгэл, найдвартай байдал, ажиллагааг үнэлэхэд чиглэсэн хэд хэдэн үе шаттай байна. Хэмжилт нь ихэвчлэн шаардагдах гол бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтоно.

1. Хэмжилтийн зорилтууд: Хэмжилт нь нэвтрүүлэх чадвар, хоцролт, багтаамж болон бусад цацаргалт гүйцэтгэлийн хэмжигдэхүүн шиг тодорхойлох зорилтуудтай.

2. Хэмжилтийн орчны тохиргоо:

- Лабораторийн хэмжилтүүд: Төрөл бүрийн нөхцөл байдлыг илэрхийлсэн, төхөөрөмж бүхий хяналттай орчин байна.
- Талбайн хэмжилтүүд: Хүрээлэн буй орчны янз бүрийн хүчин зүйлсийн гүйцэтгэлийг үнэлэхийн тулд бодит нөхцөл байдлыг ашиглах.
- Гаднын нөлөөллөөс бүрэн тусгаарлагдсан орчин (чембер)

3. Хэмжилтийн үндсэн үзүүлэлтүүд (KPI):

- **Дамжуулах чадвар:** Төрөл бүрийн ачааллын үед өгөгдөл дамжуулах хурдыг хэмжих.
- **Хоцролт:** Өгөгдөл дамжуулах саатлыг үнэлэх.
- **Дохионы чанар:** Хүлээн авсан лавлагаа дохио (RSRP), хүлээн авсан лавлагааны чанар (RSRQ), дохио-шуугианы харьцаа (SNR) зэрэг параметруудийг үнэлнэ.

4. Ачааллын хэмжилт: RRU-ийн гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээргүй, дээд даацыг нь тодорхойлохын тулд хамгийн их ачааллын нөхцөлд хэмжилт хийгдэнэ. Өөрөөр хэлбэл, RRU-ийн ачааллын дээд даацыг хамгийн өргөн зурваст, олон зөөгчтэй, олон антены MIMO 4T4R, 8T8R, 32T32R горимд хэмжихдээ бүрэн ашиглалтын үед гүйцэтгэлийн заалтууд нь 3GPP-ийн хязгаар дотор хэвээр байгаа эсэх, хэт ачааллаас хамааран үйлчилгээний чанар муудах, доголдол гарах зэргийг тодорхойлно.

5. Интерференцийн сорилт: Хос сувгийн болон зэргэлдээ сувгийн интерференцийн нөлөө байгаа үед RRU хэрхэн ажиллаж байгааг үнэлнэ.

6. Хөдлөмжийн хэмжилт: Хэрэглэгчийн төхөөрөмж (UE) хөдлөмжийн үеийн гүйцэтгэлийг үнэлэх, үүнд гардвар (handover) хийх хувилбарууд орно.

7. Гэмтэл, түүнийг сэргээх хэмжилт: Гэмтлийг зориудаар дуурайн үүсгэж, сэргээх механизмыг үнэлэх замаар найдвартай байдлыг шалгана. [Тухайлбал:](#)

A. Тэжээл тасрах (Power Failure)

- Гэмтэл: RRU-ийн үндсэн тэжээл тасарснаар төхөөрөмж унтрах.
- Сэргээх үйлдэл ба хэмжилт:

- UPS эсвэл хоёрдогч тэжээлийн эх үүсвэр ажиллаж байгаа эсэхийг шалгах.
- Тэжээл сэргэсний дараа RRU автоматаар ачаалж байгаа эсэх, CPU/FPGA boot-ыг логдож байгаа эсэхийг лог дээрээс хэмжих.
- Сүлжээний синхрончлол (GPS / PTP lock status) хэвийн болсон эсэхийг хэмжих.

Б. Дамжуулалт тасрах (Transmission Link Failure)

- Гэмтэл: RRU ба BBU (Centralized DU/CU)-ийн хоорондын CPRI/eCPRI линк унасан.
- Сэргээх үйлдэл ба хэмжилт:
 - Оптик кабел тасарсан эсэхийг шалгах → OTDR эсвэл оптик хүч хэмжигчээр хэмжих.
 - Линк сэргэсний дараа хоцролт (latency) ба jitter-ийг хэмжиж логт тэмдэглэх.
 - Алдаа гарсан хугацаанд RRU-ийн лог дээр “link down / link up” үйл явц тэмдэглэгдсэн эсэхийг шалгах.

В. RF Хэлхээ тасрах (Antenna/TX Path Fault)

- Гэмтэл: RRU-ийн нэг эсвэл хэд хэдэн RF суваг ажиллахгүй болох (PA шатсан, антен салсан).
- Сэргээх үйлдэл ба хэмжилт:
 - RF output power-ийг спектрийн анализатораар хэмжих.
 - Хэрэв нэг сектор чадал гарахгүй байвал антенны холбогч, jumper кабель шалгах.
 - Засвар хийсний дараа EVM (Error Vector Magnitude), ACLR (Adjacent Channel Leakage Ratio)-ийг хэмжиж хэвийн болсон эсэхийг баталгаажуулах.

Г. Тохиргоо/Программын гэмтэл (Configuration or Software Fault)

- Гэмтэл: RRU reboot loop-д ордог, эсвэл BBU-д attach хийхгүй.
- Сэргээх үйлдэл ба хэмжилт:
 - “Software reload / rollback хийх.
 - “Config mismatch” залруулсны дараа KPI (availability, call setup success) хэмжих.

“Тэжээл салгах”, “Дамжуулалтыг салгах” зэрэг жишээнүүд бол RRU-ийн гэмтэл, сэргээх хэмжилтийн кейсэд орно. Учир нь эдгээр нь RRU-ийн хэвийн ажиллагааг доголдуулдаг, засвар хийсний дараа хэмжилтээр баталгаажуулах шаардлагатай.

8. Хөргөх ба дулааны хэмжилт: RRU нь тогтоосон температурын хүрээнд хэвийн ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулалт хийж байгаа тохирлын лаборатори шалгана.

9. Баталгаажуулалт ба нийцлийн хэмжилт: 3GPP болон ETSI-аас тогтоосон тухайлбал [15], [16] ба [17] стандарттай нийцэж байгаа эсэхийг шалгана. Стандарт хэмжил зүйн газраас зөвшөөрөгдсөн чембер бүхий лабораторид хэмжилтийг гүйцэтгэнэ.

10. Баримтжуулалт ба тайлагнах: Шинжилгээ, нийцлийн зорилгоор хэмжилтийн журам, үр дүн болон аливаа зөрүүг бүртгэнэ.

Эдгээр аргачлалын дагуу RRU-ийн гүйцэтгэл нь 5G сүлжээний ашиглалтын техникийн үзүүлэлтүүд болон хэрэглэгчийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулж чадна.

Тайлбар: Энэхүү аргачлал RRU-ийн ажиллагааг хөндлөнгийн үнэлгээ хийхэд зориулагдсан.

5.1 Хэмжилт туршилтад бэлтгэх дараалал

5.1.1 Бэлтгэл ба тохируулга

Шаардлагатай тоног төхөөрөмжүүд:


- Чемберийн өрөө
- Хэмжилтийн хэрэгсэл (жишээ нь, сүлжээний анализатор, спектр анализатор, дохио үүсгэгч)
- RRU-д зориулсан алсын удирдлагатай интерфейс
- Антен (жишээ нь, бааз станцын антен)
- Хэмжилт тохируулга: Нарийвчлалтай хэмжилтийг баталгаажуулахын тулд хэмжилтэд ашиглах бүх төхөөрөмжийг тохируулах.

5.1.2 RRU болон хэмжилтийн орчны тохиргоо

- Байршил: RRU болон антенуудыг стандарт тохиргооны дагуу чемберийн камерт суулгах.
- Холболт: RRU-г шаардлагатай хэмжилтийн төхөөрөмж болон цахилгаан тэжээлийн үүсвэрт холбох.

5.1.3 Гүйцэтгэлийн хэмжилт

- Дамжуулах чадварын хэмжилт: Төрөл бүрийн нөхцөлд RRU-ийн ажиллах хамгийн дээд чадварыг үнэлэхийн тулд тодорхой протоколуудыг (жишээ нь, TCP/UDP) ашиглан өгөгдөл дамжуулах хурдыг хэмжинэ.
- Дохионы чанарын хэмжилт: Шалгаж тохируулсан хэмжих төхөөрөмжийг ашиглан хүлээн авсан чадлын лавлагаа дохио (Reference Signal Received Power -RSRP), Reference Signal Received Quality -RSRQ, Дохио шуугианы харьцаа SNR зэрэг параметруудийг үнэлнэ.



5.1-р зураг - 5G RRU туршилт, хэмжилтийн дараалал

- Хоцролтын хэмжилт: Дамжуулалтын хүлээн зөвшөөрөгдөх хоцрогдлын түвшнийг баталгаажуулахын тулд өгөгдөлд хүрэх хоёр талын хугацааг хэмжинэ.
- Хөндлөнгийн сорилт: Хамтарсан суваг болон зэргэлдээ сувгийн хөндлөнгийн оролцоотой үед RRU хэрхэн ажилладгийг үнэлнэ.

5.1.4 Хөдлөмжийн хэмжилт

Хүлээж авах хувилбарууд: Хэрэглэгчийн төхөөрөмжийн (UE) хөдөлгөөнийг дуурайж, RRU нь дуудлага, дамжуулалтыг зогсоохгүйгээр гардварын процессыг хэр сайн хийгдэж байгааг тэмдэглэх.

5.1.5 Ачааллын хэмжилт

Ачааллын симуляци: RRU-ээр дамжуулах ачааллын төвшнийг өөрчилж, ачаалал ихтэй нөхцөлд түүний гүйцэтгэлийг тодорхойлох, хамгийн их багтаамжийг тодорхойлох

5.1.6 Дулааны болон хүрээлэн буй орчны хэмжилт

Температур ба чийгшлийн хяналт: Төрөл бүрийн үйл ажиллагааны нөхцөлд найдвартай байдлыг хангахын тулд RRU-ийн гүйцэтгэлийг янз бүрийн температур, чийгшлийн түвшинд турших.

5.1.7 Гэмтэл болон сэргээх хэмжилт

Чадлын мөчлөгийн хэмжилтүүд: RRU-г сэргээх процессыг туршихын тулд цахилгааны гэмтлийг дуурайж, өгөгдөл алдалгүйгээр хэвийн ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой.

5.1.8 Баримтжуулалт ба үр дүн

Мэдээллийн бүртгэл: Хэмжилтийн бүх үр дүнг гажуудалтай болон тухайн бүх үр дүнг тэмдэглэх.

- Дүн шинжилгээ хийх: Гүйцэтгэлийг үнэлэхийн тулд цуглуулсан өгөгдөлд урьдчилан тодорхойлсон босго болон KPI-ийн эсрэг утгуудад дүн шинжилгээ хийнэ.

5.1.9 Нийцлийн шалгалт

- Стандартын баталгаажуулалт: Зохицуулалтын нийцлийг баталгаажуулахын тулд бүх хэмжилт, үр дүн нь холбогдох стандартад (жишээ нь, ETSI, 3GPP) нийцэж байгаа эсэхийг шалгах.

Энэхүү аргачлалыг дагаснаар инженерүүд хяналттай орчинд (гаднын нөлөөгүй тусгайлан лабораторийн нөхцөлд) 5G RRU-ийн гүйцэтгэлийн нарийвчилсан үнэлгээг хийх боломжтой бөгөөд энэ нь бодит нөхцөл байдалд ашиглахаас өмнө давуу болон сул талуудыг тодорхойлох боломжийг олгоно.

Тайлбар: 5G RRU хэмжилтийн аргачлалд Сорилт (Test) ба Хэмжилт (Measurement) гэсэн нэршлийг хэрэглэнэ.

А. Сорилт нь RRU-ийн ажиллагаа, техникийн үзүүлэлт нь стандарт болон операторын шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахад чиглэгдэнэ. Үүнийг үйлдвэрлэгчийн лаборатори, эсвэл албан ёсны баталгаажуулалтын лабораторид гүйцэтгэнэ. Жишээлбэл:

- Нэвтрүүлэгчийн чадал (Tx Power)
- Давтамжийн нарийвчлал, тогтвортой байдал
- Зурвасын өргөн
- Цацраг хэлбэржүүлэлт / олон оролт, олон гаралттай MIMO **антену** үед
- Халалт, эрчим хүчний хэрэглээ
- Хоцролт зэргийг жишиг нөхцөлд (controlled environment) гадаад орчны нөлөөлөл бага үед хийгдэнэ.

Б. RRU Хэмжилт (Measurement)

RRU бодит орчинд хэрхэн ажиллаж байгааг хэмжих, гүйцэтгэл болон чанарыг хянах зорилгоор талбай дээр (site), эсвэл туршилтын сүлжээнд хийгдэнэ. Жишээлбэл:

- Гол хэмжилтүүд:
 - S-parameters (S11, S21 гэх мэт)
 - Out of band emission (зохисгүй цацралт)
 - ACLR (Adjacent Channel Leakage Ratio)
 - EVM (Error Vector Magnitude)

- Бүрхэлт болон багтаамжийн хэмжилт
- Интерференцийн дүн шинжилгээ

Бодит радио орчинд (хөндлөнгийн оролцоо, интерференц, температур, байршлын нөлөө гэх мэт) хэмжигдэнэ.

Хүснэгт 5.1.9.1 Сорилт ба хэмжилтийн ялгаа

Нэршил	Сорилт (Test)	Хэмжилт (Measurement)
Зорилго	Стандартын шаардлага хангаж буй эсэхийг батлах	Бодит орчны гүйцэтгэлийг үнэлэх
Орчин	Лаборатори, хяналттай орчин	Талбай, бодит орчин
Аргачлал	Жишиг нөхцөлтэй, давтагдахуйц	Бодит нөхцөлтэй, олон нөлөөлөлтэй
Үр дүн	Баталгаажуулалт, сертификат	Сүлжээний чанарын үзүүлэлт, оновчлол

Өөрөөр хэлбэл:

- Сорилт нь “Тухайн RRU стандарт хангаж байгаа эсэхийг
- Хэмжилт нь RRU бодит талбай дээр хэрхэн ажиллаж байгааг тус тус харуулна.

6 5G RRU SUB-6ГГЦ ХЭМЖИЛТИЙН АРГА

5G RRU Нэвтрүүлэгчийн параметруудийн хэмжилтийн арга ба хязгаар

Чадлын тохируулгатай нэвтрүүлэгчийн бүх параметрийг хамгийн их болон дундаж чадлын түвшинд стандарт модуляцийг ашиглан хэмжинэ. Хэрэв нэвтрүүлэгчийг хаах автомат төхөөрөмжтэй бол хэмжилтийн туршид ажиллагааг түр зогсооно.

Ашиглалтын давтамжийн зөвшөөрөгдсөн хүрээ

Тодорхойлолт: Ашиглалтын давтамжийн зөвшөөрөгдсөн хүрээ нь 5G RRU-д Sub 6 ГГц болон миллиметрийн долгионд 24 ГГц-ээс дээш байна. Иймд антен болон бага шуугианы өсгөгч (LNA) нь 5G зурваст тохирох эсэхийг шалгах шаардлагатай, тухайн төхөөрөмжийг ажиллуулах эрх бүхий давтамжийн мужид байна.

6.1 А ангиллын тоног төхөөрөмжийн хэмжилтийн арга

Давтамжийн зөвшөөрөгдөх хязгаараас гадуурх хамгийн бага ба хамгийн их давтамжийг 6.1-р зурагт үзүүлсэн аргаар хэмжинэ.

“**RRU А ангиллын төхөөрөмж**” нь техникийн ангиллыг заасан нэр.

- 5G/4G системд RRU-уудыг ихэвчлэн чадлын ангилал, радио параметр, стандартын дагуу ангилдаг. “А ангилал” нь тухайн стандарт, үйлдвэрлэгчийн тодорхойлолтоор өндөр гүйцэтгэлтэй, тодорхой чадлын төхөөрөмжүүд болно.

Жишээлбэл:

Ангилал	Чадал / Цацрал	Ашиглалт
A	Өндөр / голомттой	Гол суурь эсвэл өндөр эрчимтэй бүс
B	Дунд / дэмжих	Дунд нягтралтай бүс
C	Бага / дэмжих	Дунд эсвэл бага нягтрал бүс

Товчоор хэлбэл, **RRU А ангиллын төхөөрөмж = өндөр хүчин чадалтай, гол ашиглалттай RRU** гэж ойлгож болно.

RRU-ийн ангилал:

Ангилал	RRU RF дамжуулах чадал (Transmit Power)	Хэрэглээ	Тайлбар
---------	---	----------	---------


А ангилал	~40–60Вт	Гол суурь бүс эсвэл өндөр нягтрал бүсэд RRU	RRU-ийн А, В, С ангилал нь 4G/5G системийн стандарт болон үйлдвэрлэгчийн гарын авлагад тэмдэглэснээр
В ангилал	~20–40Вт	Дунд нягтрал бүсэд RRU	
С ангилал	~10–20Вт	Бага нягтрал бүсэд, RRU	

Тайлбар:

- Тодорхой чадлын утга нь үйлдвэрлэгчээс болон сүлжээний стандарт (3GPP, LTE, NR) болон давтамжийн зургаас хамаарна.
- Эдгээр нь зөвхөн загварчилсан жишээ бөгөөд бодит утга нь RRU-ийн өгөгдлийн хуудаст заагдсан байна.

6.1.1 5G RRU – Жигд цацаргалттай эквивалент чадлын ($P_{e.i.r.p}$) тооцоолол

Энэхүү баримт бичгээр 5G RRU төхөөрөмжийн эквивалент жигд цацаргалтын чадлыг (Equivalent Isotropic Radiated Power- $e.i.r.p$) хэмжилтийн орчин, төхөөрөмжийн өсгөлт, кабелийн алдагдал, болон чөлөөт замын унтралтын нөхцөлд тооцоолох математик хувиргалтыг тайлбарлана. $P_{e.i.r.p}$ нь давтамжаас хамааралтай, чөлөөт замын унтралт болон хэмжилтийн төхөөрөмжөөс хамаарах чадлын нягт болно.

**6.1-р зураг - Ашиглалтын давтамжийн хүрээг хэмжих тохируулга****Тооцоолол:**

Тохиргооны бүрэлдэхүүнүүдийн логарифм болон шугаман утгуудын шилжилт:

$$g_{LNA} = 20\log(G_{LNA}) \quad (6.1) \text{ ба}$$

$$g_A = 10\log(G_A) \quad (6.2)$$

$$cl_x = 10^{\left(\frac{cl_x}{20}\right)} \quad (6.3)$$

Логарифм чадлын хувилбар:

$$p_{e.i.r.p} = p_m - g_A - cl1 - cl2 - g_{LNA} + 20 \cdot \log\left(\frac{4\pi r}{\lambda}\right) \quad [\text{дБ/МГц}] \quad (6.4)$$

Шугаман чадлын хувилбар:

$$P_{e.i.r.p} = \frac{P_m \cdot (4\pi r)^2}{G_{LNA} \cdot \lambda^2 \cdot G_A \cdot cl1 \cdot cl2} \quad [\text{МВт/МГц}] \quad (6.5A)$$

$$p_{e.i.r.p} = p_m - g_A - cl1 - cl2 - g_{LNA} + 20 \cdot \log\left(\frac{4\pi r}{\lambda}\right) \text{ [МВт/МГц]} \quad (6.5B)$$

Хувьсагчийн утгын тайлбар:

Тэмдэглэгээ

 p_m
 g_{LNA}, G_{LNA}
 g_A, G_A
 $cl_x,$
 λ
 r
 $\frac{4\pi r}{\lambda}$
 λ

Тайлбар

Хэмжигч төхөөрөмжид бүртгэгдсэн чадал [дБ/МГц]

LNA урьдчилан өсгөгчийн логарифм болон шугаман өсгөлт

Антену логарифм болон шугаман өсгөлт

Кабелийн алдагдлын лог утга (1-ээс бага шугаман утгатай)

Долгионы урт ($\lambda = c / f$)

Хэмжилтийн антен хүртэлх зай (метр)

Чөлөөт замын унтралтын коэффициент

Жишээ тооцоолол:

- $G_{LNA} = 20$ (урьдчилан өсгөгчийн өсгөлт)
- $G_A = 10$ (антену өсгөлт)
- $cl1 = cl2 = 0.89$ (кабелийн алдагдал)
- $\lambda = 0.0857$ м (давтамж 3.5 ГГц)
- $r = 3$ м
- $P_m = -40$ дБ/МГц


Энд, $cl1$ ба $cl2$ нь кабелийн алдагдлын утгууд нэгээс бага байна. Үүний үр дүнд $cl1$ ба $cl2$ логарифмын утгууд нь сөрөг байна.

Хэмжилтийн талбайг сонгохдоо (жишээ нь, дотор болон гадна задгай хэмжилтийн талбайд) тогтоосон давтамжийн муж болон энэ хэмжилтийн хамгийн бага тогтоосон цацаргалтын түвшний шаардлагыг хангасан хэмжилтийн талбайг ашиглана.

6.1.2 5G RRU – Цацраг хэлбэржүүлэлт болон цацаргалтын графикууд

1. Beam Pattern – Polar Plot


Зураг 6.2-т А ангиллын RRU төхөөрөмжийн цацраг хэлбэржүүлэлтийн чадвартай холбоотой чиглэл дагасан цацаргалтын график (polar plot) үзүүлэв. Цацрагийн үндсэн чиглэлд хамгийн өндөр өсгөлттэй байх ба ердийн косинус тархалтаар түвшин буурна.



6.2-р зураг - Чиглэл дагасан Beam Pattern (Polar Plot)

2. Цацаргалтын түвшин – EIRP, өнцөг


Зураг 6.3-т өнцгийн өөрчлөлттэй уялдуулан e.i.r.p-ийн түвшин хэрхэн өөрчлөгдөхийг харуулсан. Цацаргалтын үндсэн чиглэлд хамгийн өндөр e.i.r.p гарч байгаа нь дохионы төвлөрлийг харуулна.



6.3-р зураг - EIRP түвшин өнцгөөс хамааран (EIRP vs Angle).

3. Давтамжийн өсгөлт

Зураг 6.4-т 3.3–3.8 ГГц давтамжийн хүрээнд антены өсгөлт хэрхэн өөрчлөгдөж буйг жишээ болгон харуулж байна. Синусойд хэлбэртэй өөрчлөлт нь бүтэц, элементүүдийн зохион байгуулалтаас хамаарсан өсгөлтийн өөрчлөлтийг харуулж байна.



6.4-р зураг - Давтамжийн дагуух чиглэлийн өсгөлт.

6.2 Давтамжийн муж

Ашиглалтын давтамжийн зөвшөөрөгдөх хүрээ нь 0.96 ГГц - 2.2 ГГц, 2.2 ГГц-ээс 8 ГГц хүртэл (хүснэгт 6.2.1) [18]

5G RRU-ийн ашиглах давтамжийн зөвшөөрөгдсөн хүрээ нь тухайн улс орны зохицуулагч байгууллагаас баталсан радио давтамжийн хуваарилалтад үндэслэнэ.

Ашиглалтын давтамжуудын ангилал:

0.96 ГГц – 2.2 ГГц:

- Энэ хүрээ нь LTE Band 8 (900 МГц) болон 5G Band n1 (2100 МГц) зэрэгт хамаарах.
- RRU ашиглаж болох давтамж бүхий зурвас, үүнд:
- n1 (1920–1980 МГц uplink / 2110–2170 МГц downlink)

- n5, n8 зэрэг FDD зурвасууд орно.
- Бага цацаргалттай нөхцөл шаардахгүй.

2.2 ГГц – 8.0 ГГц:

- Энэ хүрээний зарим зурвасууд 5G-д ашигладаг ч:
- 3.3–4.2 ГГц (Band n78, n77) — хамгийн түгээмэл Sub-6ГГц 5G зурвасууд.
- 6 ГГц орчим нь Wi-Fi 6E / 7 болон боловсруулж буй IMT-2020 зурвасууд орно.
- Зохицуулалттай цацаргалтын түвшин шаардана.
- Ашиглалтад хуурамч цацаргалтын (SE), EIRP хязгаар, цахилгаан соронзон нийцлийн (EMC) шаардлагуудыг хангах ёстой. Зөвхөн 5G RRU төхөөрөмжийн хэмжилтийн тохиргоонд зориулсан давтамжийн зурвасуудыг IMT-2020 (5G) зориулалттай зурваст үндэслэн Монгол Улсад ХХЗХ-оос **2023.09.13 өдрийн №106 тогтоолоор** баталсан зурвасуудыг хүснэгт 6.2.1-д үзүүлэв.

6.2.1-р хүснэгт - Монгол Улсад 5G RRU хэмжилт хийхэд тохирох давтамжийн зурвасууд [19]

3GPP Band	Давтамжийн хүрээ (МГц)	Хэмжилтийн зорилгод тохиромжтой	Санал болгож буй тохиргоо
n28	703–748 (UL) / 758–803 (DL)	Хөдөөгийн бүсэд 5G RRU	RBW: 1 МГц / VBW: 3 МГц
n78	3300–3800	Хот суурин газрын 5G RRU	RBW: 1–5 МГц / VBW: 3–10 МГц
n3	1710–1785 (UL) / 1805–1880 (DL)	LTE-Advanced зурваст 5G NR DSS (Dynamic Spectrum Sharing)	DSS хэмжилт хийх бол тохиромжтой
n1	1920–1980 / 2110–2170	DSS бүхий зурваст тохиромжтой	EIRP хэмжилт хийх
n8, n5	880–960	Хязгаарлагдмал өргөн зурвастай	Хэмжилт хийхэд өргөн зурвас дутмаг
n257, n258	24.25–29.5 ГГц (мм долгион)	Монголд одоогоор ашиглагдаагүй	mmWave хэмжилтэд тохирно

Монгол Улсад 5G RRU-ийн хэмжилт хийхэд ашиглах боломжтой зурвасууд:

- n28 (700 МГц) — алслагдсан газарт тохиромжтой
- n78 (3.5 ГГц) — хот, үйлдвэрийн орчинд стандарт
- n3/n1 — Шууд дарааллын аргаар спектрийг өргөтгөсөн (DSS) ашиглаж буй тохиолдолд тохиромжтой.

Хамгийн түгээмэл хэмжилтийн зурваст техникийн хэмжилтэд ашиглах тохиргооны жишээ:

- Зурвас n78 (3300–3800 МГц):
- 5G Sub-6ГГц зурвас

Хэмжилт хэмжилтэд:

- RBW (Resolution Bandwidth): 1 МГц
- VBW (Video Bandwidth): 3 МГц
- Reference level: +10 to +30 дБмВт
- Detector: RMS or Peak

Спектрийн анализаторын тохиргооны жишээ:

Төвийн давтамж: 3500 МГц

- Span: 100 МГц
- RBW: 1 МГц
- VBW: 3 МГц

- Sweep time: Auto
- Detector: RMS
- Attenuation: 0–10дБ

6.3 5G RRU-ийн цацаргалтыг хэмжих.

5G RRU-ийн хэмжилтийн тохиргоо:

5G RRU-ийн хэмжилт хийхэд дараах тохиргоонуудыг ашиглана:

- Давтамжийн зурвас: Байршил болон операторын ашиглаж буй зурвасаас хамааран сонгоно (жишээ нь, 3.5 ГГц зурвас).
- RBW (Resolution Bandwidth): 1 МГц
- VBW (Video Bandwidth): 3 МГц
- Detector: RMS эсвэл “Peak”
- Sweep Time: Автомат эсвэл тохирох утгаар
- Унтралт: 0–10 дБ

Эдгээр стандартуудыг ашиглан 5G RRU-ийн хэмжилтийг олон улсын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх боломжтой. 5G RRU-ийн хэмжилтийн стандарт тохиргоонд 5G RRU төхөөрөмжүүдийн хамгийн их зөвшөөрөгдөх цацаргалт (e.i.r.p)-ийн хэмжээг давтамжийн цараа болон өнцгийн хамааралтайгаар дараах байдлаар тодорхойлогдоно:

6.3.1-р хүснэгт - 5G RRU хэмжилтийн e.i.r.p хязгаарууд (дБ/МГц)

Давтамжийн муж [ГГц]	Хэвтээ хавтгайд ($-20^{\circ} \rightarrow +30^{\circ}$)	Өндрийн өнцгүүдэд ($-90^{\circ} \rightarrow +20^{\circ}$, $+30^{\circ} \rightarrow +90^{\circ}$)
$f < 1.73$	—	-85 дБ/МГц
$1.73 \leq f < 2.2$	-70	-65
$2.2 \leq f < 2.5$	-	-50
$2.5 \leq f < 2.69$	-70 (харин LBT ашиглавал -50)	-65 (LBT ашиглавал -50)
$2.69 \leq f < 2.7$	-75	-55
$2.7 \leq f < 2.9$	-70	-50
$2.9 \leq f < 3.4$	-70	-50
$3.4 \leq f < 3.8$	-70	-50
$3.8 \leq f < 4.8$	—	-50
$4.8 \leq f < 5$	-75	-55
$5 \leq f < 5.25$	—	-50
$5.25 \leq f < 5.35$	-60	-50
$5.35 \leq f < 5.6$	—	-50
$5.6 \leq f < 5.65$	-65	-50
$5.65 \leq f < 5.725$	-60	-50
$5.725 \leq f < 8.5$	—	-50
$8.5 \leq f < 10.6$	—	-65
$f \geq 10.6$	—	-85

Тайлбар Шуугианы төвшнөөс дээш цацаргалт илрээгүй бол, хэмжилтийн UE UWB цацаргалтын цараанд зөвшөөрөгдсөн хязгаар биелсэн гэж үзнэ.

Хэмжилтийн практик хэрэглээ:

- 5G RRU төхөөрөмжийг шалгахдаа:
- Спектрийн анализаторт дээрх хязгааруудаар EIRP спектрийн нягтралыг шалгана.
- Налалтын өнцөг бүрд (хэвтээ болон босоо) чиглэлээр тохирох e.i.r.p хязгаарт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.


Хүснэгт 6.3.1. 5G RRU төхөөрөмжийн ашиглаж болох давтамжийн муж болон хамгийн их зөвшөөрөгдөх цацаргалт (e.i.r.p) үзүүлэлтүүдийг хэмжилтийн өнцгийн хамааралтайгаар үзүүлсэн.

6.4 Зөвшөөрөгдөөгүй (Unwanted Emission) цацаргалтын хэмжилтийн арга

5G RRU-ийн нийт цацаргалтын (Total Emissions-TE) хэмжилт нь зөвшөөрөгдөх хязгаарыг зөрчиж буй эсэхийг шалгахад зориулагдана.

6.4.1 5G RRU-ийн нийт цацаргалтын (Total Emissions TE) хэмжилт

Зураг 6.4.1-д 5G RRU-ийн нийт цацаргалтын (TE) мэдээллийг харуулсан. Энэхүү хэмжилт нь 5G RRU хэрэглэгчийн төхөөрөмжид тавигдах эмиссын хязгаар Хүснэгт 6.3.1) болон стандартыг хангасан эсэхийг шалгахад ашиглаж Зураг 6.4.1-д зарим 1 давтамжийн мужид зөвшөөрөгдөх хязгаарыг давсан үзүүлэлтүүд байна.



6.4.1-р зураг - 1.8-2.6 ГГц давтамжийн мужийн 5G RRU-ийн нийт цацаргалтын хэмжилтийн график.

Графикийн гол агуулга:

- Х тэнхлэг: Давтамжийн муж (Frequency [ГГц])
- Y тэнхлэг: EIRP буюу Effective Isotropic Radiated Power [дБм/МГц]
- Хар муруй: RRU-ийн бодит нийт цацаргалт (Total Emissions)
- Цэнхэр шулуун: UWB UE emission limits (6.4.1) буюу хэрэглэгчийн төхөөрөмжид тавигдах хязгаар (эмиссын стандарт хязгаар)
- Улбар шар дугуй тэмдэглэгээ: Хязгаар хэтэрсэн хэсгүүд (UE limits exceeded)
- Зураг 6.4.1-д RRU-ийн давтамжийн зурвасын гадуурх буюу хажуугийн цацаргалтыг харуулж байна.
- Цахилгаан соронзон нийцэл (Electromagnetic Compatibility- EMC) болон зохицуулалтын нийцэл (regulatory compliance) шалгалтуудад зайлшгүй шаардлагатай.
- Хэрэв цацаргалт зөвшөөрөгдөх хязгаараас давсан бол төхөөрөмжийг ашиглахыг хориглох, дахин тохируулах шаардлагатай.

Энэ хэмжилт нь 5G RRU-ийн журмын нийцэл, интерференц үүсгэхгүй байх, улс орон бүрийн радио давтамжийн зохицуулалтад нийцэж буй эсэхийг тодорхойлоход шаардлагатай стандарт шалгуур юм.

1.8–2.6 ГГц давтамжийн зурваст:

- Band 3 (1800 МГц) – FDD
- Band 7 (2600 МГц) – FDD
- Band 38/40/41 – TDD (TD-LTE)

Эдгээр зурвасууд нь ихэвчлэн:

- 4G LTE системд эсвэл NSA (Non-Standalone 5G) дэд бүтцэд ашигладаг.
- 5G NR-ийн зарим зурвас (Band n41: 2496–2690 МГц) орж болно.

5G RRU 3.5 ГГц буюу Band n78 (3300–3800 МГц):

- 5G NR Standalone (SA) болон Non-Standalone (NSA) горимд ашиглагддаг C-band зурвас.
- Үндсэн 5G өндөр хурдны дата үйлчилгээ
- Энэхүү зурваст зориулсан RRU нь өөр өөр RF дизайн, антен, болон зөвшөөрлийн шалгууртай.

6.4.1-р хүснэгт - 5G RRU 1.8–2.6 ГГц ба 3.5 ГГц буюу Band n78 (3300–3800 МГц)

Үзүүлэлт	1.8–2.6 ГГц	3.5 ГГц (n78)
Давтамжийн зурвас	Band 3/7/41 гэх мэт	Band n78
Ашиглалт	LTE / NSA anchor	5G NR primary carrier
RRU-ийн төрөл	4G эсвэл NSA Hybrid	5G NR RRU

Тухайн 3.5 ГГц (n78) зурваст ажиллаж буй RRU-аас 1.8–2.6 ГГц зурваст үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлоход энэ хэмжилтийг ашиглана.

Нийт цацаргалт (TE) нь зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE) эсвэл бусад цацаргалтын (OE) хязгаараас хэтэрсэн давтамжийн мужуудын хувьд бусад зөвшөөрөгдөөгүй цацаргалтуудыг нэвтрүүлэгч эсвэл антеныг салгаж идэвхгүй болгох замаар хэмжинэ. Хэмжилтийн тодорхойгүй байдлын хүрээнд ижил агууригтай OE болон TE-д байгаа цацаргалтыг OE гэж үзнэ.

6.4.2 5G RRU-ийн бусад цацаргалтын (OE) хэмжилт

Зураг 6.5.1 нь 5G RRU буюу нэвтрүүлэгч төхөөрөмжийн бусад цацаргалтыг (OE) хэмжсэн үр дүнгийн жишээг харуулна.

Хэмжилтийн үр дүн нь зарим мужид зөвшөөрөгдөх хязгаарыг давж байгаа нь дүрслэгдсэн байна. Ийм төрлийн хэмжилт нь төхөөрөмжийн зохицуулалтын шаардлагад нийцэж буй эсэхийг тогтооход зайлшгүй шаардлагатай.

Бүх хэмжилтийг удаан хугацаанд хийх боломжтой байхын тулд тасралтгүй цацаргалтаас зайлсхийхийн тулд хэрэгжүүлсэн механизмуудыг хэмжилтийн зорилгоор жишээ нь завсарлага, хөдөлгөөн мэдрэгч, гарын авлагын товчлуурыг идэвхгүй болгоно.

RRU нь бусад цацаргалт зурвасуудад хөндлөн интерференц үүсгэж байгаа эсэх, мөн тухайн давтамжийн UWB эсвэл UE emission limits-ыг зөрчиж байгаа эсэхийг илрүүлдэг. Хэмжилтийн тодорхой бус байдал (uncertainty)-г тусгаж өгсөн нь техникийн тайланд ач холбогдолтой.

- RRU conformity testing
- Regulatory compliance тайлан
- Unwanted Emission (UE), Other Emission (OE) хэсэгт тайланд оруулах
- Тоног төхөөрөмжийн pre-certification болон lab test-ийн тайлан гаргах

6.5 Нийт цацаргалтын (TE) хэмжилтийн арга

5G RRU-ийн хувьд:

- 3D антен диаграм, beam sweeping зэргийг шалгах шаардлагатай
- Цууриагүй чембер буюу долгион тусгаарласан өрөөнд хэмжилт хийх шаардлагатай
- ETSI EN 301 908-13, 3GPP 38.141-1, эсвэл FCC стандартуудын дагуу хэмжинэ.

5G RRU Хэмжилтийн стандарт, схем ба тайлангийн загвар

Хэмжилтийн зорилго:

- Энэ баримт бичиг нь 5G RRU-ийн цацаргалттай холбоотой хэмжилтүүдийг гүйцэтгэхэд ашиглагдах стандарт аргачлал, схем болон тайлангийн загварыг агуулна. Үүнд дараах хэмжилтүүд хамаарна:
- Нийт цацаргалт (TE)
- Зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)
- Бусад цацаргалт (OE)
- Хажуу сувгийн алдагдал (ACLR)
- Нэвтрүүлэх хамгийн их хурд ба цацраг хэлбэржүүлэлтийн хэмжилт

Ашигласан стандартууд:

- 5G RRU хэмжилтэд дараах олон улсын стандартуудыг дагаж мөрдөнө:
- 3GPP TS 38.104: Base Station (BS) radio transmission and reception
- 3GPP TS 38.141-1: NR Base Station conformance testing
- ETSI EN 301 908-13: IMT cellular networks; Harmonised Standard for access to radio spectrum
- FCC Part 30 (АНУ-д ашиглагддаг бол)
- ITU-R SM.329, SM.1541 (interference, spurious emissions)

Хэмжилтийн ерөнхий схем:

Хэмжилт нь долгион тусгаарласан орчин цуурайгүй чемберт хийгдэнэ. Дараах үндсэн бүрэлдэхүүнүүдтэй байна:

- 5G RRU төхөөрөмж
- Хэмжилтийн антен (жигд цацаргалттай болон чиглүүлэмжтэй антен)
- Спектр анализатор эсвэл Дохионы аиализатор
- Антену байрлал тохируулах систем (Antenna positioning system)
- Үндсэн зурвасын симулятор (gNB симулятор эсвэл UE эмүлятор)
- Кабель ба холболтын төхөөрөмжүүд

Цацаргалтын хэмжилтийн программ (Keysight, Rohde & Schwarz)

Тайлбар: 5G RRU-ийн цацаргалтын хэмжилтийн программын нэр болон хувилбар г нь ихэнхдээ Keysight Signal Studio for 5G NR, Rohde & Schwarz R&S@WinIQSIM2™, эсвэл Anritsu MP1900A зэрэг мэргэжлийн хэмжилтийн программ хангамжууд байна. тухайн байгууллагын ашиглаж буй төхөөрөмжийн үйлдвэрлэлийн он, лицензээр тодорхойлогдоно.

Монгол орны нөхцөлд операторууд ихэвчлэн эдгээрээс сонгон ашигладаг тул хэмжилтийн схем, RBW/VBW тохиргоо, unwanted/spurious emission хэмжилтэд тохиромжтой.

Хэмжилтийн нөхцөл:

- Давтамжийн зурвас: n78 (3.4–3.8 ГГц) эсвэл тухайн операторын ашиглаж буй зурвас
- Чадал: 30–43 дБм (гадна суурилуулалт)
- Антену өндөр ба зай: 1.5–3 метр, 3–5 метрийн радиустай
- Орчны температур: 20–25°C
- DUT (Device Under Test) нь PUSCH эсвэл SSB дамжуулж байх

Хүснэгт 6.5.1 5G RRU-ийн цацаргалтын хэмжилтийн программ, түүний хувилбар

Программын нэр	Хувилбар (жишээ)	Үйлдэл / зориулалт	Тохиргоо / Заавар	Тайлбар
Keysight Signal Studio for 5G NR	22.0/ 2025	5G NR сигнал үүсгэх, цацаргалтын хэмжилт хийх	RBW: 1–5 МГц, VBW: 3–10 МГц	Хот суурин газрын 5G RRU-ийн хэмжилтэд тохиромжтой.
Rohde & Schwarz R&S@WinIQS IM2™	21.1/ 2024	5G NR сигнал симуляци хийх, Зөвшөөрөгдөөгүй цацахгалт (UE) шалгах	RBW: 1 МГц, VBW: 3 МГц	Хөдөөгийн бүсийн 5G RRU-ийн хэмжилтэд тохиромжтой.
Anritsu Signal Quality Analyzer MP1900A	V2.1/ 2023	5G NR RRU-ийн хуурамч/зөвшөөрөгдөөгүй цацаргалтыг хэмжих	RBW: 1–5 МГц, VBW: 3–10 МГц	DSS бүхий зурвас болон mmWave хэмжилтэд
Цацаргалтын хэмжилтийн схем	-	Холбогдсон RRU → Spectrum Analyzer → PC/Measurement Software	RRU-г холбож, цацаргалт хэмжих, хуурамч/зөвшөөрөгдөөгүй цацаргалтыг анализ хийх	Монголын операторуудын туршилтад үндэслэн тохируулагдсан схем

Монгол улсын 5G RRU Цацаргалтын хэмжилтийн схем

[5G RRU] ---> [Spectrum Analyzer] ---> [PC / Measurement Software]

- > Keysight Signal Studio for 5G NR (v22.0)
- > R&S WinIQSIM2™ (v21.1)
- > Anritsu MP1900A (v2.1)


+--> Монголын давтамжийн зурвас
n28: 703–748 / 758–803 МГц (хөдөө)
n78: 3300–3800 МГц (хот)
n3: 1710–1785 / 1805–1880 МГц (DSS)
n1: 1920–1980 / 2110–2170 МГц (DSS)
n257/n258: 24.25–29.5 GHz (ммWave)

- 5G RRU: Үндсэн цацаргалтын төхөөрөмж
- Spectrum Analyzer: Цацаргалтын хүч, unwanted/spurious emission хэмжих
- Measurement Software: Хэмжилтийн өгөгдлийг бүртгэх, анализ хийх
- Давтамжийн зурвас: Монгол Улсад одоогоор ашиглагдаж буй 5G зурвасууд

RBW / VBW тохиргоо:

- n28: RBW 1 МГц / VBW 3 МГц
- n78: RBW 1–5 МГц / VBW 3–10 МГц
- n3 / n1: DSS хэмжилтэд тохиромжтой
- n257/n258: mmWave хэмжилтэд тохирно.

Жишээлбэл:



Mongolian

- n28: 703–748 / 758–803 MHz (ходөөе)
- n78: 3300–3800 MHz (хот)
- n3: 1710–1785 / 1805–1880 MHz (DSS)
- n1: 1920–1980 / 2110–2170 MHz (DSS)
- n257/n258: 24.25–29.5 GHz (mmWave)

- Keysight Signal Studio for 5G NR (v22.0)
- R&S WinIQSIM2™ (v21.1)
- Anritsu MP1900A (v2.1)

Зураг 6.5.1 Монгол улсын 5G RRU Цацаргалтын хэмжилтийн схем

Тайлангийн загвар

Доорх бүтэцтэйгээр тайлан бэлтгэнэ:

- Хэмжилтийн орчны зураг
- Ашигласан төхөөрөмжийн жагсаалт
- Хэмжилтийн аргачлал (стандартуудын дагуу)
- Хэмжилтийн үр дүн (график, хүснэгт хэлбэрээр)
- Дүгнэлт ба нийцлийн үнэлгээ


Бүх хэмжилтэд хэвийн ажиллагааны дохиог ашиглана.

- Спектрийн анализаторын төвийн давтамжийг шаардлагатай давтамжид тохируулна.
- Давтамжийн спектрийн сегментийн тохиромжтой эсэхийг шалгахын тулд давтамжийн хүрээг тохируулна уу.
- RBW-г 1 МГц, VBW-ийг 3 МГц болгож тохируулна уу.
- Детекторыг RMS-д тохируулна уу.
- Хэмжлийн цэг бүрд нэг мс-ээс илүүгүй буюу түүнээс бага интеграцийн хугацаа байхаар хугацааг тохируулна уу.

Хэмжих хамгийн бага түвшинд шаардлагатай мэдрэмжийг авахын тулд илүү нарийвчлан зурвасын өргөнийг тохируулах шаардлагатай. Үүнийг хэмжилтийн тайлангийн маягтад тусгана.

Хэмжилтийн явцад DUT-ийг барилгын байгууламж дээр антенныг нь шууд тусахаар хэмжилтийн антенныг 0.8 м-ээс 1.5 м-ийн зайд байрлуулна.

Хэмжилтийн антенны туйлшрал нь хэмжилтийн цэг бүрийн үндсэн талбайн бүрэлдэхүүн хэсгийн туйлшралыг хангасан байх ёстой. Тиймээс хэмжилтийн антенныг хамгийн өндөр утгыг авах хүртэл цэг бүрд эргүүлж болно. Өөр нэг боломжит арга бол хоёр ортогональ туйлшралын чиглэлтэй хэмжих антенныг ашиглах явдал юм. Холбогдох хэмжилтийн утга нь дугуй болон бүх туйлшралын өнцөг дээрх хамгийн их утга юм.



**6.5.1-р зураг - 5G RRU хэмжилтийн геометр ба өнцгийн тодорхойлолт.
А ангиллын төхөөрөмжийн цацаргалтын бүх (TE, UE, OE, UE-TP) хэмжилтүүд**

6.5.1 5G RRU талбайн хэмжилтийн тайлангийн загвар

Суурилуулсан 5G RRU төхөөрөмжийн бодит орчинд үзүүлж буй сүлжээний гүйцэтгэл, цацраг хэлбэржүүлэлт, нэвтрүүлэх чадамж, дохионы хүчлэгийг шалгах.

Хэмжилтийн орчны нөхцөл:

Байршил: BTS сайт дээр

- Хэмжилтийн арга: Drive test, Walk test, Fixed Point Test

- Ашиглах төхөөрөмж: UE, Scanner, Spectrum Analyzer, GPS

Тайлбар: Scanner – тухайн RRU-ийн гаргаж буй дохио, давтамжийн хамрах хүрээ, чанар зэргийг хэмжих багаж/программ юм.

1. Спектрийн шинжилгээ

- Carrier Frequency, Bandwidth шалгах
- Unwanted / Spurious Emission хэмжих

2. Сүлжээний параметрийн илрүүлэлт

- PCI (Physical Cell ID), SSB (Synchronization Signal Block)
- Beam ID болон Beamforming шинжилгээ

3. Покрывтие буюу хамрах хүрээний хэмжилт

- Drive Test хийж газар дээрх бодит тархалтыг харах

Ашиглагддаг Төхөөрөмж / Програмууд

- Keysight FieldFox – spectrum + 5G NR analysis
- Rohde & Schwarz TSMx / ROMES4 – network scanner
- Anritsu Spectrum Master, BTS Master – 5G RRU хэмжилт
- Nemo Outdoor / TEMS Investigation – scanner software (drive test-д хэрэглэнэ)

Хэмжилтийн Ерөнхий Схем


1. RRU → Antenna → Scanner Device
 - Антеннаар дамжуулан RRU-ийн сигнал хүлээн авна.
2. Scanner Software
 - Сүлжээний параметруудийг уншиж, тайлан гаргана.
3. Analysis / Report

Хэмжих үзүүлэлтүүд:

- DL/UL Throughput Уруудах/өгсөх шугамын хамгийн их дамжуулах чадамж буюу багтаамж
- SINR, RSRP, RSRQ
- Beam tracking Цацрагийн замчлал
- Interference level Интерференцийн түвшин
- Cell coverage mapping Үүрийн бүрхэлтийн зураглал

Ашиглагдах программ хангамж, төхөөрөмж:

- UE сорилт төхөөрөмж (Qualcomm, Samsung test UE)
- Drive test төхөөрөмж (TEMS, Nemo Outdoor)
- Iperf, UDP/TCP сорилт хэрэгсэл
- GPS, лог бүртгэгч программ



6.5.2-р зураг - Лабораторийн болон гадна талбайд цацаргалтын бүх хэмжилтийг (TE, UE, OE, UE-TP) хийх

6.6 Хэмжих 5G RRU хүлээн авагчийн шаардлагууд

Энэхүү баримт бичиг нь 5G RRU-ийн хэмжилт хийх үед хүлээн авагчийн тохиргоонд шаардлагатай нэмэлт төхөөрөмжүүдийн зориулалт, тохирох нөхцөл, антены төрөл болон бага шуугианы урьдчилан өсгөгч (LNA), хүлээн авагчийн мэдрэмжийг нэмэгдүүлэх, өндөр давтамжтай дохионы, дохио шуугианы харьцааг (SNR) сайжруулах, хуурамч цацаргалт (SE) болон цацраг хэлбэржүүлэлтийн туршилтад зайлшгүй шаардлагатай, шуугиантай орчинд дохио илрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

6.6.1-р хүснэгт - Антены төрөл ба хэрэглээ

Антенны төрөл	Давтамжийн муж	Ашиглах нөхцөл
Диполь антен	< 1 ГГц	Нам зурвасын цацаргалт шалгах
Horn антен	1–18 ГГц	Цацраг хэлбэржүүлэлтийн чиглүүлэмжтэй хэмжилт
Log-periodic антен	700 МГц – 6 ГГц	Өргөн зурвасын бүрхэлтийн орны туршилт
Жигд цацаргалттай антен	< 3.5 ГГц	Дохионы ерөний бүрхэлт, орны хэмжилт

LNA шаардлагатай нөхцөлүүд:

- Цуурайгүй камер буюу чемберт хийх хэмжилтүүд (хуурамч (SE) ба зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE))
- Нам давтамж (< 1 ГГц) хэмжилт
- SNR бага нөхцөлд дохио хүлээн авах шаардлагатай үед
- Цацрагийн замчлал, бага чадлын замын хэмжилт (low power path test)

Хүлээн авагчийн тохиргооны схем:


Доорх схемийн дагуу хүлээн авагчийн талын антен ба хэмжилтийн төхөөрөмжүүд дараалан холбогдоно:

- Антен (Horn, Dipole, гэх мэт)
- LNA (шүүлтүүр бүхий бага шуугиант өсгөгч)
- Кабель (low-loss RF cable)
- Спектр анализатор

Хүлээн авагчийн тохиргооны зураг (Receiver Chain Diagram)

Зураг 6.6.1 нь 5G RRU-ийн дохионы хэмжилтийн системийн дарааллыг харуулсан. Антен → LNA → Анализатор гэсэн дараалалтайгаар тохиргоо хийгдэх бөгөөд LNA

нь дохионы түвшнийг нэмэгдүүлж, бодит хэмжилтийг гүйцэтгэх боломжийг сайжруулдаг.




6.6.1-р зураг - 5G RRU хүлээн авагчийн тохиргооны блок диаграмм.

Бага шуугианы өсгөгч (LNA) хүлээн авагчийн мэдрэмжийг сайжруулах, нам түвшний дохиог хэмжихэд ач холбогдолтой. 1 ГГц-ээс доош эвэр ба диполь антен ашиглана.

6.6.1 5G RRU eirp хэмжилт

RRU-ийн хэвтээ болон босоо талаас хэмжих өнцөг:

RRU төхөөрөмжийн цацаргалтын өнцгийг хэмжихэд голлон ашигладаг налалтын өнцгийн хүрээ нь $+30^\circ$ болон -20° хооронд байна. Доорх зургаар RRU-гийн байрлалаас хамааран дохио хүлээн авах талбайн ялгаатай хязгаарыг харуулж байна. Энэхүү өнцгийн хүрээ нь хуурамч ялгаруулалт болон цацрагийн өргөний тооцоололд ашиглана.



6.6.2-р зураг - RRU төхөөрөмжийн цацаргалтын босоо хазайлтын өнцгийн хязгаарлалт.

5G RRU – Хэмжилтийн зохион байгуулалт ба орон зайн шаардлага


Энэхүү баримт бичиг нь 5G ангиллын RRU төхөөрөмжийн лабораторийн болон талбайн Хэмжилтийн орчны орон зайн шаардлага болон цацаргалтын дээд түвшнийг тодорхойлох өнцгийн хүрээг тайлбарлана.

Орон зайн шаардлагууд

- RRU–антен хоорондын зай: 3–5 метр
- RRU-ийн өндөр (h): 1.5–2 метр
- Хэмжих радиус (r): 1–3 метр
- Налалтын өнцөг: -20° – $+30^\circ$
- Антен болон RRU-ийн хооронд шулуун харагдах шугамтай (LoS) байх
- Цацраг хэлбэржүүлэлтийн хэмжилт хийх боломжтой 3D зохион байгуулалт
- Цуурайгүй чөмбөр эсвэл тусгаарлагдсан орчин шаардлагатай.

Цацаргалтын дээд түвшний өнцгийн хүрээ

Зураг 6.6.3-т RRU төхөөрөмжийн e.i.r.p-ийн хамгийн өндөр түвшнийг тооцоолж болох босоо болон хэвтээ өнцгийн хүрээг харуулсан. Энэ хүрээнд хэмжилтийг хийх нь хамгийн оновчтой цацаргалтын чиглэлийг тодорхойлоход тусална.



6.6.3-р зураг - RRU-ийн цацаргалтын хамгийн их түвшнийг тодорхойлох өнцгийн хүрээ.

Pe.i.r.p. чөлөөт орны унтралт ба хэмжилтийн төхөөрөмжөөс хамаарах давтамжийг харгалзан UWB мэдрэгчийн чадлын нягтын лавлагаа байршил юм.

$$\begin{aligned} g_{LNA} &= 20\log(G_{LNA}) \\ g_A &= 10\log(G_A) \\ cl_x &= 10\left(\frac{cl_x}{20}\right) \end{aligned} \quad (6.6) \quad (6.7) \quad \text{ба} \quad (6.8)$$

Децибеллээр илэрхийлбэл:

$$p_{e.i.r.p.wall} = p_m - g_A - cl1 - cl2 - g_{LNA} + 20 \cdot \log\left(\frac{4\pi r}{\lambda}\right) \quad [\text{дБм/МГц}] \quad (6.9)$$

Шугаман тэгшитгэлээр илэрхийлбэл:

$$P_{e.i.r.p.wall} = \frac{P_m \cdot (4\pi r)^2}{G_{LNA} \cdot \lambda^2 \cdot G_A \cdot cl1 \cdot cl2} \quad [\text{mW/МГц}] \quad (6.10)$$

Кабелийн алдагдлын утгууд $cl1$ ба $cl2$ нь нэгээс бага байна. Тиймээс $cl1$ ба $cl2$ логарифмын утгууд сөрөг байна!

Сонгогдсон хэмжилтийн талбай (дотор хэмжилтийн талбай эсвэл задгай талбайн хэмжилтийн талбай) нь шаардлагыг хангасан байна. Энэ хэмжилтийн тогтоосон давтамжийн муж болон хөндөгдөөгүй хамгийн бага тогтоосон цацаргалтын түвшнийг ашиглана.

Зөвшөөрөгдөөгүй цацаргалтыг зөв хэмжихийн тулд хэмжих хүлээн авагчийн зурвасын өргөнийг зохих утгад тохируулна. Энэ зурвасын өргөнийг хэмжилтийн тайланд тэмдэглэнэ. DUT-ийн нийт хамгийн их цацаргалтын (TE) түвшнийг хэмжиж, бүртгэнэ. Шаардлагатай хэмжилтийн үр дүнг гаргаж авахын тулд спектр анализаторын оролтод бага шуугианы өсгөгч (LNA) ашиглахыг зөвлөдөг.

Хэмжих хүлээн авагчийн давтамжийг 30 МГц-ээс 26 ГГц хүртэлх давтамжийн мужид тохируулна. Хуурамч бүрэлдэхүүн хэсэг бүрийн давтамжийг тэмдэглэнэ. Хэмжилтийн талбай гаднаас ирж буй цацрагийн нөлөөгөөр өөрчлөлт орсон бол энэ чанарын хайлтыг шаардлагатай бол нэвтрүүлэгч болон хэмжилтийн антены хоорондох зай багатай дэлгэцтэй өрөөнд хийж болно.

Хэмжилтийн системийн бага шуугианы урьдчилан өсгөгчийг хэт ачааллаас хамгаалахын тулд урьдчилан сонгосон зөв шүүлтүүрийг оруулна. Түүнчлэн хэмжсэн спектрүүдэд байгаа орчны дохионы хувь нөлөөг арилгахын тулд нэвтрүүлэгчийг идэвхжүүлэхээс өмнө бүх орчны дохиог илрүүлнэ. Энэ нь компьютер болон

өгөгдлийн шинжилгээний программ хангамж ашиглан хэмжилтийн өгөгдлийн дараах боловсруулалтыг шаарддаг. Цацаргалтын дБм/МГц-ийн утгыг (ТЕ-хэмжилт) 960 МГц-ээс 10.6 ГГц хүртэлх хэмжсэн давтамж болон хэмжилтийн байрлалын тоон мэдээллийн багцын функц байдлаар хадгална.

6.6.2 Бусад цацаргалтыг (ОЕ) хэмжих арга


Хэмжилтийг дараах байдлаар гүйцэтгэнэ.

- Шаардлага хангасан хэмжилтийн талбайд заасан өндөрт хэмжих антенныг тулгуур дээр байрлуулна.
- Нэвтрүүлэгчийг салшгүй антентайгаар ердийн хэвийн модуляцтайгаар ажиллуулна.
- Хэмжих хэрэгслийн нарийвчлалын зурвасын өргөн нь хэмжиж буй хуурамч бүрэлдэхүүн хэсгийн спектрийн өргөнөөс их, хамгийн бага зурвасын өргөн байх ёстой.

Дараагийн хамгийн их зурвасын өргөн нь агууригийг 1 дБ-ээс бага өсгөхөд үүссэн тохиолдолд үр дүнг хүрсэн гэж үзнэ. "Хэмжилтийн нарийвчлал, мэдрэмж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд нягтралын зурвасын өргөн нь жишиг зурвасын өргөнөөс өөр байж болно. Нарийвчлалын зурвасын өргөн нь жишиг зурвасын өргөнөөс бага байх үед үр дүнг жишиг зурвасын өргөн дээр нэгтгэх хэрэгтэй. Нарийвчлалын зурвасын өргөн нь стандартаас их байх үед жишиг зурвасын өргөн, өргөн зурвасын хуурамч цацаргалтын үр дүнг зурвасын өргөний харьцаатай хэвийн болгох хэрэгтэй лавлагаа зурвасын өргөнийг ашиглах боломжтой." (CEPT/ERC/REC 74-01).

Холбогдох хэмжилтэд ашигласан нөхцөлүүдийг хэмжилтийн тайланд тусгана.

- Давтамж бүр дээр бүрэлдэхүүн хэсгүүдийг илрүүлэх хэмжих элементийг хамгийн их хариу үйлдэл үзүүлэхээр эргүүлэх ба 6.6.4-р зурагт үзүүлсэн хэмжилтийн зохицуулалтыг ашиглан орлуулах хэмжилтээр тухайн бүрэлдэхүүн хэсгийн эффектив цацаргалтын чадлыг тодорхойлно.
- Тухайн бүрэлдэхүүн хэсгийн эффектив цацаргалтын чадлын утгыг бүртгэнэ.
- Хэмжилтийг хэмжилтийн антенаар ортогональ туйлшралын хавтгайд давтан гүйцэтгэнэ.



Тэмдэглээ 1: Дохионы генератор

Тэмдэглээ 2: Орлуулах антен

Тэмдэглээ 3: Хэмжилтийн антен

Тэмдэглээ 4: Спектр анализатор эсвэл сонгомол вольтметр (хүлээн авагч)

6.6.4-р зураг - Хэмжилтийн зохион байгуулалт

6.6.3 Төхөөрөмжийн ангилал, түүний хязгаарууд

А ангиллын хязгаар:

UWB зөвшөөрөгдөөгүй цацаргалтын хэмжсэн утга $Pe.i.r.p.$ нь 6.6.1-р хүснэгтэд заасан хязгаараас хэтрэхгүй байх.

$Pe.i.r.p$ нь давтамжийн хязгаараас гадна цацаргалт нь бөмбөрцөг байршилд бас хязгаарлагдана. Эдгээр хязгаарлалтыг хэвтээ хязгаарлалт гэнэ.

6.6.2-р хүснэгт - Хамгийн их дундаж $e.i.r.p$ -ийн хязгаар.

Бараг суурин суурилуулалтын спектрийн нягтрал (А ангилал)

Давтамжийн цараа [ГГц]	Хамгийн их $e.i.r.p$ (-90°- +20° болон +30°- +90° налалтын өнцөгт) [дБм/МГц]	Хамгийн их $e.i.r.p$ хэвтээ хавтгайд (-20°- +30° налалтын өнцөгт) [дБм /МГц]
$f < 1.73$ (2 болон 3 дугаар тайлбарыг харах)	-85	
$1.73 \leq f < 2.2$ (2 болон 3 дугаар тайлбарыг харах)	-65	-70
$2.2 \leq f < 2.5$	-50	
$2.5 \leq f < 2.69$ (2 болон 3 дугаар тайлбарыг харах)	-65	-70 (Тайлбар 1-ийг харах)
$2.69 \leq f < 2.7$	-55	-75
$2.7 \leq f < 2.9$	-50	-70
$2.9 \leq f < 3.4$	-50	-70
$3.4 \leq f < 3.8$	-50	-70
$3.8 \leq f < 4.8$	-50	
$4.8 \leq f < 5$	-55	-75
$5 \leq f < 5.25$	-50	
$5.25 \leq f < 5.35$	-50	-60
$5.35 \leq f < 5.6$	-50	
$5.6 \leq f < 5.65$	-50	-65
$5.65 \leq f < 5.725$	-50	-60
$5.725 \leq f < 8.5$	-50	
$8.5 \leq f < 10.6$	-65	
$f \geq 10.6$ (2 болон 3 дугаар тайлбарыг харах)	-85	

ТАЙЛБАР 1: Зарим давтамжийн хүрээнд UWB цацаргалтын хязгаар нь маш бага чадалтай радио дохиотой төстэй бөгөөд эдгээр нь аналог болон дижитал хэлхээнээс үүсэх цацаргалтын чадлын хязгаартай адил байна. Хэрэв UWB төхөөрөмжийн цацаргалт нь UWB цацаргалтад хамаарахгүй гэдгийг тодорхой харуулж чадах (жишээ нь, төхөөрөмжийн UWB нэвтрүүлэгчийг унтраах, эсвэл хэмжилтийн тодорхой бус байдалд бусад цацаргалт (OE) ба UWB нэвтрүүлэгчийн зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)-ийн ялгааг тодорхойлох боломжгүй болохыг нотолбол, энэхүү цацаргалтыг бусад цацаргалтад (OE) хамааруулан үзнэ.

ТАЙЛБАР 2: Хэмжилтийн тохиргоог оновчтой болгосны дараа ч бусад цацаргалт OE эсвэл зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE) нь шуугианы доод хэмжээнээс дээш илрэх боломжгүй бол, тухайн тохиолдолд зөвшөөрөгдөөгүй цацаргалтын (UE) хязгаар биелэгдсэн гэж үзнэ.

В ангиллын хязгаар:

UWB зөвшөөрөгдөөгүй цацаргалтын (UE) хэмжсэн утга $Pe.i.r.p.$ нь 6.6.3 хүснэгтэд заасан хязгаараас хэтрэхгүй байх.

6.6.3-р хүснэгт - UWB цацаргалтын В ангиллын хязгаар

Давтамжийн цараа [ГГц]		В ангиллын тоног төхөөрөмжийн хамгийн их дундаж e.i.r.p спектрийн нягтрал [дБмВт/МГц]
$f < 1.73$	(3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-85
$1.73 \leq f < 2.2$	(3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-70
$2.2 \leq f < 2.5$		-50
$2.5 \leq f < 2.69$	(Тайлбар 1-ийг харах)	-65
$2.69 \leq f < 2.7$	(2, 3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-70
$2.7 \leq f < 2.9$	(3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-70
$2.9 \leq f < 3.4$	(Тайлбар 1-ийг харах)	-70
$3.4 \leq f < 3.8$	(Тайлбар 2-ыг харах)	-50
$3.8 \leq f < 4.8$		-50
$4.8 \leq f < 5$	(Тайлбар 2-ыг харах)	-55
$5 \leq f < 5.25$		-50
$5.25 \leq f < 5.35$		-60
$5.35 \leq f < 5.6$		-50
$5.6 \leq f < 5.65$		-65
$5.65 \leq f < 5.725$		-60
$5.725 \leq f < 8.5$		-50
$8.5 \leq f < 10.6$	(3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-65
$f \geq 10.6$	(3 болон 4 дүгээр тайлбарыг харах)	-85
ТАЙЛБАР 1: Duty Cycle 1 секунд тутамд 10%-иар хязгаарлагддаг. ТАЙЛБАР 2: Зарим давтамжийн хүрээнд UWB цацаргалтын хязгаар нь маш бага чадалтай радио дохиотой адил бөгөөд эдгээр нь дижитал болон аналог хэлхээнээс үүсэх цацаргалтын чадлын хязгаартай ижил байна. Хэрэв UWB төхөөрөмжийн цацаргалт хүснэгт 6.6.3-д заасан UWB цацаргалтад хамаарахгүй гэдгийг тодорхой харуулж чадах (жишээ нь, бусад цацаргалт (OE) ба UE цацаргалтын хоорондох ялгааг тодорхойлох боломжгүй бол, тухайн цацаргалтыг бусад цацаргалтад (OE) хамааруулан үзнэ		

6.6.4 Бусад цацаргалт (OE)

Бусад цацаргалт (жишээ нь, нарийн зурвасын хуурамч цацаргалт, аналог эсвэл тоон удирдлагын хэлхээний цацаргалт) нь нэвтрүүлэгчийн эзэлсэн давтамжийн зөвшөөрөгдсөн хязгаараас гадуур давтамж эсвэл давтамж дээр DUT-ийн антенаас эсвэл түүний кабинетаас цацруулж буй цацаргалтыг хэлнэ. Ийм хуурамч цацаргалт нь гармоник цацаргалт, паразит цацаргалт, интермодуляцын бүтээгдэхүүн, давтамж хувиргалтын явцад үүсэх бүтээгдэхүүнүүд орно.

Хэмжилтийн арга:

Хэмжилтийн арга нь 6.6.2-р бүлэгт заасан аргачлалтай ижил байна.

Хязгаарлалт:

Хуурамч цацаргалтын бүсэд эдгээр цацаргалтын аль нэгийн жигд цацаргалттай эквивалент чадал нь 6.6.4-р хүснэгтэд заасан утгаас хэтрэхгүй байх ёстой.

6.6.4-р хүснэгт - Бусад цацаргалтын хязгаар

Давтамжийн цараа	Бусад цацаргалтын (OE) хязгаарын утгууд
47 МГц - 74 МГц	-54 дБмВт/100 кГц

87.5 МГц - 118 МГц	-54 дБмВт /100 кГц
174 МГц - 230 МГц	-54 дБмВт /100 кГц
470 МГц - 862 МГц	-54 дБмВт /100 кГц
Бусад цацаргалт 30 МГц - 1 000 МГц-ийн завсарт	-36 дБмВт /100 кГц
1 000 МГц - 40 000 МГц (Тайлбар харах)	-30 дБмВт /1 МГц
ТАЙЛБАР: Зөвшөөрөгдсөн давтамжийн хүрээнд UE цацаргалтад дээрх хязгаар утгууд хамаарахгүй.	

6.6.5 Нийт чадлын спектр нягт (UE-TP)

Зөвшөөрөгдөөгүй цацаргалтын нийт чадлын спектр нягт (UE-TP) нь дараах байдлаар тодорхойлогдоно. Нэмэлт нь зөвхөн В ангиллын төхөөрөмжид шаардлагатай.

$$PSD = \frac{|E_{rms}|^2}{Z_{F0}} \quad (6.11)$$

Үүнд: $Z_{F0} = 120\pi\Omega$ чөлөөт орон зайн долгионы эсэргүүцлийг илэрхийлнэ. Орны хүчлэгийн RMS дундаж квадрат утгыг дараах аргаар олно.

$$E_{rms} = \frac{|E|}{\sqrt{2}} \quad (6.12)$$

Үүнд: E нь цахилгаан орны агууриг

Спектр анализатор ашиглан чадлын урсгалыг дараах байдлаар тодорхойлно.

$$S = \frac{P_r}{A_r} \quad (6.13)$$

Үүнд: P_r нь хүлээн авах антены коннектор дээрх чадал ба A_r нь хүлээн авах антены эффектив талбай

Нийт чадал дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$TP = \int_{\Theta=0}^{\pi} \int_{\Phi=0}^{2\pi} S \times r^2 \times \sin(\Theta) d\Theta d\Phi \quad (6.14)$$

Энд r нь бөмбөрцгийн радиус, Θ нь өндийх өнцөг, Φ нь азимутын өнцөг юм.

Хэмжилтийн арга

Хэмжилт хийх журам нь 6.6.2-р бүлэгт заасан аргачлалтай ижил байна. Цахилгаан орны хүчлэгийг болон чадлыг хэмжихдээ RBW-ийг 1 МГц, VBW-ийг 3 МГц болгон тохируулна.

Бөмбөрцөг гадаргуу дээр 0.8 м-ээс 1.5 м-ийн зайд хамгийн ихдээ 15° тутамд (өнцөг бүрийн хувьд) хэмжилтийг хийнэ.

Хязгаарууд

e.i.r.p. нийт чадлын спектр нягтын хязгаар (UE-TP) нь Хүснэгт 6.6.4-д заасан хязгаараас хэтрэхгүй байх ёстой.

В ангиллын төхөөрөмж нь нийт цацаргалтын чадлын шаардлагыг хангасан байх ёстой.

6.6.4-р хүснэгт - Нийт чадлын спектр нягтын хязгаар (UE-TP)

Давтамжийн царай [ГГц]	Хязгаарын утгууд [дБм/МГц]
$2.69 \leq f < 2.7$ (Тайлбар 1, 2-ыг харах)	-80
$3.4 \leq f < 4.8$	-60
$4.8 \leq f < 5.0$	-60
ТАЙЛБАР 1: Хэрэв цацаргалтыг хэмжих явцад (TE болон OE хэмжилт) тодорхой нэг давтамж дээр (UE) хязгаарыг нарийн илрүүлэх боломжгүй тохиолдолд, үүнд илүү хүчтэй non-UWB	

дохио эсвэл хэмжилтийн тохиргооны үеийн шуугиан нөлөөлсөн байж болно Энэ тохиолдолд тухайн давтамж дээр UE-TP хязгаарыг тодорхойлох боломжгүй бөгөөд уг давтамж дээр UE-TP хязгаар хангагдсан гэж үзнэ.

ТАЙЛБАР 2: Хэрэв UE хязгаарыг хэмжилтийн гадаргуугийн зарим хэсэгт л тодорхойлж, хэмжих боломжтой бол UE-TP хязгаарыг зөвхөн тэр хэсгүүдэд үндэслэн тооцно.

Үйлчилгээ үзүүлэгч нь ердийн хэмжилтийн дохиог дамжуулах үед төхөөрөмжөөр дамжих импульсийн хугацааны тодорхойлолтыг өгч, нэвтрүүлэгчийн PRF-ийг зарлана.

7 ЦУУРАЙГҮЙ КАМЕР БУЮУ ЧЕМБЕРИЙН ӨРӨӨНД 5G RRU ХЭМЖИЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

Чемберийн өрөөний шаардлагатай хэмжүүрийн багажийн жишиг.

- Vector network analyzer
- Spectrum analyzer
- RF signal generator
- Selective radiation meter
- RF calibration & test kits
- Anechoic chamber
 - SNF-RAZ-0.7 (0.5-20ГГц)
 - Near-field measurement
 - Far-field calculation
- Simulation software
 - CST Studio Suite
 - Path Wave Advanced Design System (ADS)
- Broadband Probe Antenna
- NSI-RF-RGP-40 (4.0-40 ГГц), NSI-RF-RGP-10 (0.7-10 ГГц), NSI-RF-RGP-370 (0.37-6 ГГц)
- Standard Gain Horn Assembly (ANT-SGA-0.75-26.5-ABS)
- Antenna positioning and control system (0.5-20ГГц, антены хэмжээ: Диаметр-0.7м, 18кг хүртэл)
- PNA network analyzer (Keysight N5222B 10 МГц - 26.5 ГГц)
- VNA network analyzer (Keysight E5063A 10 МГц to 6 ГГц)
- Rig Expert antenna analyzer (1400 МГц хүртэл)

7.1 5G RRU хамгийн их дамжуулах чадамжийг (5G RRU Throughput Testing Plan) хэмжих

Төрөл бүрийн сүлжээ болон ачааллын нөхцөлд 5G RRU-ийн уруудах болон өгсөх шугамын багтаамж буюу дамжуулах чадамжийг хэмжих, баталгаажуулах.

1. Хэмжилтийн орчны тохиргоо:

Шаардлагатай тоног төхөөрөмж:

- 5G RRU
- 5G UE симулятор эсвэл хэмжилтийн UE (Хэрэглэгчийн төхөөрөмж)
- Цөм сүлжээний эмулятор (хэрэв бодит сүлжээ ашиглаагүй бол)
- Ачааллын генератор (iPerf3, Spirent, IxLoad)
- Хяналтын хэрэгсэл (Wireshark, протокол анализатор)
- Linux/Windows үйлдлийн системтэй компьютер/сервер

Сүлжээний топологи:

- RRU нь Distributed Unit (DU) эсвэл gNB-д холбогдсон
- Агаарын интерфэйсээр (эсвэл загварчилсан холболт) RRU-д холбогдсон UE-г турших
- DU болон Core Network Emulator хооронд Ethernet backhaul

2. Хэмжилтийн хувилбарууд:

- **Хувилбар 1: Уруудах шугамын хамгийн их дамжуулах чадвар**
 - RRU болон UE-г 100 МГц зурвасын өргөн, n78 зурваст тохируулна.
 - 4x4 MIMO тохиргоог ашиглах
 - UDP ашиглан серверээс UE руу iPerf3 урсгалыг дамжуулах
- **Хувилбар 2: Өгсөх шугамын хамгийн их дамжуулах чадвар**
 - Дээрхтэй ижил тохиргоо хийнэ.
 - UDP ашиглан UE-ээс сервер рүү iPerf3 урсгалыг дамжуулна.
- **Хувилбар 3: Олон хэрэглэгчийн ачааллын Хэмжилт**
 - 5-аас 50 хүртэлх UE-г симуляц хийнэ.
 - Нэгтгэсэн дамжуулах чадвар болон хэрэглэгч бүрийн шударга байдлыг (user-fairness) хэмжих
- **Хувилбар 4: Хувьсах MCS & PRB хуваарилалт**
 - MCS-ийн янз бүрийн утгуудын дамжуулалтын сорилтыг ажиллуул
 - Өөр өөр тооны PRB хуваарилах
- **Хувилбар 5: Бодит интерференцийн нөлөө**
 - удирдлагатайгаар интерференцийг нэвтрүүлэх, дамжуулах чадварыг дахин хэмжих

3. Хэмжилтийн командууд өгөх**4. Бичлэг хийх хэмжүүр:****7.1.1-р хүснэгт - 5G RRU хамгийн их дамжуулах чадварын хэмжилт**

Хэмжилтийн төрөл	Тодорхойлолт
Уруудах шугамын дамжуулах чадамж	Серверээс UE хүртэлх өгөгдлийн хурд
Өгсөх шугамын дамжуулах чадамж	UE-ээс сервер хүртэлх өгөгдлийн хурд
Хоцролт	Дамжуулах чадварын хэмжилтийн үед хоёр талын дамжууллын хоцролт
Багцын алдагдал	Хэмжилтийн явцад алдагдсан багцуудын хувь
Життер	Багц саатлын өөрчлөлт
CPU-ийн ашиглалт	Ачааллын үед RRU нөөцийн ашиглалт

5. Баталгаажуулалт:

- Хэмжсэн дамжуулах чадварыг онолын максимумтай харьцуулах
- 3GPP нэвтрүүлэх чадварын стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах
- Ачааллын дор саад тотгор, доройтолд дүн шинжилгээ хийх

6. Хэмжилтийн хэрэгсэл:

- Wireshark (PCAP файлын шинжилгээ)
- Лог задлан шинжлэхэд зориулсан Python/Pandas
- Статистикийн тайлбарт зориулсан Stata/SPSS (заавал биш)

7. Бүртгэлжүүлэлт:

- Хэмжилтийн үр дүнгийн бүртгэл
- Дамжуулах график (DL/UL ба цаг хугацаа, хэрэглэгчийн тоо)
- Гүйцэтгэлийн тайлбар бүхий хураангуй тайлан

8. Тэмдэглэл:

- Хэмжилтийн UE болон үндсэн хооронд синхрончлолыг баталгаажуулна.
- Лабораторийн нөхцөлд хэмжилт хийж байгаа бол RF-ийн хамгаалалтыг хадгална.
- Амжилтгүй болсон хэмжилтийн тохиолдлуудыг ижил тохиргооны дагуу дахин ажиллуулна.

7.2 5G RRU лабораторийн хэмжилтийн тайлан загвар

5G RRU төхөөрөмжийн радио давтамжийн гүйцэтгэлийг олон улсын стандартын дагуу долгион тусгаарласан орчинд цуурайгүй чөмбөр хэмжин баталгаажуулах зорилготой.

Хэмжилтийн орчны нөхцөл:

- Хэмжилтийн орчин: Anechoic chamber
- Хэмжих зай: 3–5 метр
- Орчны температур: 20–25°C
- Антен: Omni эсвэл Horn төрөл

Ашиглагдах стандартууд:

- 3GPP TS 38.104
- 3GPP TS 38.141-1
- ETSI EN 301 908-13
- ITU-R SM.329

Хэмжих үзүүлэлтүүд:

- Хамгийн их дамжуулах чадал (Tx Power)
 - Adjacent Channel Leakage Ratio (ACLR)
 - Spectrum Emission Mask (SEM)
 - Spurious Emissions (Unwanted Emissions)
 - UE Interface Emissions

7.2.1-р хүснэгт - Хэмжилтийн жишиг үр дүн жишээ

Үзүүлэлт	Хэмжилт (дБм)	Стандарт хязгаар
Нэвтрүүлэх чадал	42.1	≤ 43 дБм
ACLR	42.5	≥ 45 дБ
SEM @ ±10 МГц	-30	≤ -25 дБм/МГц
Spurious Emission	-45	≤ -43 дБм
UE Interface Leakage	-50	≤ -47 дБм

7.3 5G RRU нэвтрүүлэгчийн асаах / унтраах (on/off) үеийн чадлын хэмжилт

RRU асаалттай болон унтраалттай үед нэвтрүүлэгчийн чадлын түвшнийг хэмжих замаар төхөөрөмжийн ажиллагааг шалгах.

1. Хэмжилтийн орчин:

Төхөөрөмжүүд:

- 5G RRU
- Спектрийн анализатор эсвэл чадал хэмжигч
- Үндсэн зурвасын хэсэг (Baseband Unit -BBU)
- Шаардлагатай бол хэмжилтийн хэрэглэгчийн төхөөрөмж (UE)
- Хамрах зурвас: n78 (жишээ нь 3.5 ГГц)
- Сувгийн өргөн: 100 МГц

- Хэмжилтийн хэрэгсэл: Спектр анализатор (Max Hold болон Marker функцтэй)

2. Хэмжилтийн алхмууд:

Алхам 1: RRU унтраалттай үеийн хэмжилт

- RRU-г идэвхгүй буюу дамжуулалт унтраалттай горимд байлгах.
- Спектрийн анализатораар фоны шуугианы түвшнийг хэмжих.
- Хүлээгдэж буй үр дүн: Доогуур шуугианы түвшин, жишээ нь -90 дБм-аас доош.

Алхам 2: RRU асаалттай үеийн хэмжилт

- BBU-с дамжуулалтыг идэвхжүүлж, PDSCH өгөгдөл дамжуулах.
- Спектрийн анализатораар чадлын өсөлтийг ажиглах.
- Дундаж болон дээд чадлыг тэмдэглэх.
- Хүлээгдэж буй үр дүн: Жишээ нь 40 дБм орчим нэвтрүүлэгчийн чадал

7.3.1-р хүснэгт - Хэмжилтийн үр дүнгийн жишээ

Төлөв	Давтамж (МГц)	Хэмжигдсэн чадал (дБм)
Нэвтрүүлэгч унтраалттай	3500	-93 дБм
Нэвтрүүлэгч асаалттай	3500	+40 дБм

- Хэмжилтийн үед интерференцийн дохио нөлөөлөхгүй байх.
- Орны хэмжилт хийх нөхцөлд чиглүүлэмж бүхий холбогч (coupler) эсвэл Хэмжилтийн порт ашиглах.

5G RRU-ийн (Remote Radio Unit) нэвтрүүлж буй дохионы чанарыг хэмжих нь сүлжээний гүйцэтгэл, хэрэглэгчийн туршлагыг хангах шалгуур юм. Үүнийг хэмжихдээ дараах гол үзүүлэлтүүдийг ашиглана:

7.4 5G RRU-ийн нэвтрүүлж буй дохионы чанарыг хэмжих

7.4.1-р хүснэгт - 5G RRU-ийн нэвтрүүлж буй дохионы чанарын үзүүлэлт

Үзүүлэлт		Хэмжих хэрэгсэл / Арга
RSRP (Reference Signal Received Power)	Бааз станцын дохионы хүчийг хэмждэг.	UE log, Scanner, Drive Test Tool
RSRQ (Reference Signal Received Quality)	Дохионы чанар ба интерференцийг харуулдаг.	UE log, Drive Test Tool
SINR (Signal-to-Interference and Noise Ratio)	Дохионы ашигтай харьцаа. Өндөр байх тусам сайн.	Spectrum Analyzer, UE log
EVM (Error Vector Magnitude)	Илгээгдсэн ба хүлээн авсан дохионы алдааны хэмжээ.	Vector Signal Analyzer
ACLR (Adjacent Channel Leakage Ratio)	Хажуугийн сувгууд руу алдагдсан чадлын харьцаа.	Spectrum Analyzer
SEM (Spectrum Emission Mask)	Спектрийн хэтрэлт стандарттай нийцэж буй эсэх.	Spectrum Analyzer
Beam Quality (SS-RSRP, SS-SINR)	Beamforming дохионы чанарыг шалгах үзүүлэлт.	Drive Test, Field Scanner

7.4.1. Хүлээн авсан дохионы лавлагаа дохио (RSRP), хүлээн авсан дохионы чанарын лавлагаа (RSRQ), дохио шуугиан, интерференцийн харьцаа (SINR) хэмжих

Хэрэгсэл: Drive test tool (e.g. TEMS, Nemo Outdoor) эсвэл test UE

Алхам:

- Хэрэглэгчийн төхөөрөмжийг (UE) RRU-гийн ойролцоо байрлуулах.
- Сорилт горимд ажиллуулж PDSCH эсвэл SSB дохионы чанарыг лог файлд бичих.
- Дохионы чанарыг график болон тайланд тусгах.

7.5 EVM хэмжих модуляцийн чанарын сорилт:

- Хэрэгсэл: Vector Signal Analyzer (e.g., Keysight, R&S)
- Тооцооллын илэрхийлэл

$$EVM (\%RMS) = \sqrt{\frac{|\sum S_{meas} - S_{ideal}|^2}{\sum |S_{ideal}|^2}} \times 100 \quad (7.1)$$

S_{meas} : Хүлээн авсан дохионы вектор

S_{ideal} : Тохирсон(ideal) модуляцийн дохио

Алхам:

- RRU-гээс PDSCH эсвэл сорилт дохио дамжуулна.
- Analyzer дээр IQ constellation-г бичиж авна.
- Соронзон векторын алдааны (Error Vector Magnitude -EVM) үзүүлэлт 3GPP TS 38.104 стандарттай нийцэж буй эсэхийг шалгана.
 - QPSK $\leq 17.5\%$
 - 16QAM $\leq 12.5\%$
 - 64QAM $\leq 8\%$
 - 256QAM $\leq 3.5\%$

7.6 Spectrum Emission Mask (SEM) болон (Adjacent Channel Leakage Ratio - ACLR) шалгах

ACLR нь зэрэгцээ сувгууд руу алдагдсан дохионы чадлын харьцаа юм. Энэ нь тухайн сувгийн дохио бусад зөвшөөрөгдөөгүй цацаргалт сувгууд руу алдагдаж байгаа эсэхийг шалгадаг үзүүлэлт юм. Өндөр ACLR-ийн утга нь интерференц бага, илүү цэвэр дамжуулалт гэсэн үг.

Тооцооллын томьёо:

$$ACLR (dB) = \log_{10} \left(\frac{P_{main}}{P_{adjacent}} \right) \quad (7.2)$$

P_{main} : Үндсэн сувгийн дамжуулалтын дундаж чадал

$P_{adjacent}$: Дэргэдэх сувгийн дундаж чадал

7.6.1 SEM болон ACLR хэмжих арга:

- RRU-г нэвтрүүлж буй гол сувгийг төв давтамжид тохируулна.
- Analyzer дээр Spectrum Plot авна.

- Хажуугийн сувгууд руу дохионы алдагдлыг хэмжиж, стандарт (≥ 45 дБ) хангаж буй эсэхийг шалгана.

7.6.2 Тайлангийн загвар (Жишээ):

- Дохионы чанарын хэмжилтийн тайлан
- RRU загвар:
- Хэмжилтийн огноо: 2025-04-16
- Байршил: Ulaanbaatar Test Site
- Хэмжилтийн үр дүн:

7.4.2-р хүснэгт - 5G RRU дохионы чанарын хэмжилтийн тайлан

№	Үзүүлэлт	Хэмжсэн утга	Хүлээгдэж буй стандарт	Нийцэл	Хэмжилтийн огноо	RRU загвар
1	RSRP	-82	>-95 дБм	Тийм	2025-04-16	RRU-X1000
2	RSRQ	-9	>-12 дБ	Тийм	2025-04-16	RRU-X1000
3	SINR	23.5	>20 дБ	Тийм	2025-04-16	RRU-X1000
4	EVM (QPSK)	4.2	$\leq 17.5\%$	Тийм	2025-04-16	RRU-X1000
5	EVM (256QAM)	2.8	$\leq 3.5\%$	Тийм	2025-04-16	RRU-X1000
6	ACLR	47	≥ 45 дБ	Тийм	2025-04-16	RRU-X1000
7	SEM	Passed	Passed	Тийм	2025-04-16	RRU-X1000

Дүгнэлт (Жишээ):

RRU нь 3GPP-ийн шаардлагад нийцэж байгаа бөгөөд дохионы чанар сайн байна.
3GPP Стандартын эшлэлүүд

- 3GPP TS 38.104 – NR Base Station RF requirements
https://www.3gpp.org/ftp/Specs/archive/38_series/38.104/
- 3GPP TS 38.141-1 – Conformance Testing Part 1: RF
https://www.3gpp.org/ftp/Specs/archive/38_series/38.141-1/
- 3GPP TS 38.141-2 – Part 2: Radiated
https://www.3gpp.org/ftp/Specs/archive/38_series/38.141-2/
- IEC 62232 – BS RF Exposure Standard

5G RRU-ийн динамик цараа нь тухайн RRU-ийн хүлээн авах эсвэл дамжуулах дохионы хамгийн өндөр болон хамгийн бага боломжит чадлын түвшин хоорондын зөрүүг дБ-р илэрхийлснийг харуулна.

7.7 Динамик царааг тодорхойлох:

Динамик цараа нь RRU-ийн эсвэл ямар нэгэн RF төхөөрөмжийн дэмжиж чадах хамгийн хүчтэй дохио болон хамгийн сул (шуугианаас ялгарахуйц) дохио хоорондын дээд хязгаар юм.

$$\text{Dynamic Range (dB)} = P_{\max} - P_{\min} \quad (7.3)$$

$P_{\max}$: Хамгийн өндөр чадал (RRU-ийн дамжуулж чадах дээд утга)

$P_{\min}$: Хамгийн бага ялгаж чадах дохио (receiver sensitivity)

5G RRU-ийн динамик царааны утгууд:

7.7.1-р хүснэгт - Динамик царааны утгууд


Үзүүлэлт	Утга (жишээ)
Хамгийн их чадал	+40 дБм (10 Ватт)
Хүлээн авах мэдрэмж	-110 дБм
Динамик цар	150 дБ

Энэ нь RRU нь -110 дБм дохио хүлээж авч чаддаг, +40 дБм хүртэл дамжуулж чаддагийг харуулж байна. 150 дБ динамик цараа нь өндөр чанартай RRU-ийн үзүүлэлтэд тооцогдоно.

Динамик цараа:

7.7.2-р хүснэгт - Динамик царын хэрэглээ

Ашиглах зорилго	Тайлбар
Өндөр ба нам дохио ялгах	Хол ойрын хэрэглэгчдийг зэрэг хүлээж авах боломж
Шуугиан ба интерференцээс ялгах	Бага дохионуудыг ч зөв ялгаж авна
Beamforming болон MIMO-д ашигтай	Хүчтэй/сул дохионы ялгаатай нөхцөлд ч ажиллана
Хэмжилт хийх чадвар	Спектрийн анализ, дохионы анализ хийх боломжтой

5G Динамик цараа

7.7.1-р зураг - 5G RRU-ийн динамик цараа

- Хөх сумтай хэсэг нь RRU хүлээн авч чадах хамгийн бага дохио (Receiver Sensitivity: -110 дБмВт)
- Улаан сумтай хэсэг нь RRU-ийн дамжуулж чадах хамгийн өндөр дохио (Max Tx Power: +40 дБм)
- Цэнхэр зурвас нь тэдгээрийн хоорондох динамик цараа (150 дБ).

7.8 5G RRU-ийн нэвтрүүлэх дохионы чанар

5G RRU-ийн нэвтрүүлэх дохионы чанар нь тухайн RRU-гийн дамжуулж буй дохио хэр цэвэр, нарийн, хэр стандарттай нийцсэн байгааг илэрхийлнэ.

7.8.1-р хүснэгт - 5G RRU-ийн нэвтрүүлэх дохионы чанарын үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тайлбар
Алдаа векторын хэмжээ EVM (Error Vector Magnitude)	Модуляцийн алдааны түвшин. Дохио хэр нарийн илгээгдэж байгааг хэмждэг.
Зэргэлдээх сувгийн алдагдлын харьцаа ACLR (Adjacent Channel Leakage Ratio)	Хажуугийн сувгууд руу алдагдсан чадлын хэмжээ. Интерференцийг багасгах шалгуур.
Спектр ялгаруулах маск SEM (Spectrum Emission Mask)	Спектрийн хэтрэлтийн график. Стандарттай нийцэж буй эсэхийг шалгана.
Нэвтрүүлэх чадлын нарийвчлал (Tx Power Accuracy)	Дамжуулалтын чадлын жинхэнэ болон тохиргооны утгын зөрүү.
Давтамжийн алдаа (Frequency Error)	Илгээгдэж буй дохионы бодит болон хүссэн давтамжийн зөрүү.

IQ Imbalance	I/Q (in-phase, quadrature) дохионуудын тэнцвэртэй байдал.
Фазын шуугиан (Phase Noise)	Давтамжийн хэлбэлзэл, цэвэршилтийн үзүүлэлт.

EVM – Илгээх дохионы алдааны нарийвчлал:

Модуляцын төрөл бүрд дараах EVM шаардлага тавигдана (3GPP TS 38.104):

7.8.2-р хүснэгт - Модуляцлагдсан дохионы үзүүлэлтүүд

Хүснэгт	Хүснэгт
QPSK	$\leq 17.5\%$
16QAM	$\leq 12.5\%$
64QAM	$\leq 8\%$
256QAM	$\leq 3.5\%$

ACLR – Хажуугийн сувгийн алдагдлыг шалгах:

RRU өөрийн суваг дээр дамжуулал хийх үед хажуугийн сувгууд руу чадал алдсанаас хөрш сувагт интерференц үүсгэнэ. Энэ нь 3GPP стандартын дагуу ACLR ≥ 45 дБ байна.

SEM – Спектрийн хэтрэлтийн хязгаар

- Илгээгдэж буй дохио стандартын маскны хязгаар дотор байх ёстой.
- Энэ нь бусад цацаргалт системд нөлөөлөхөөс сэргийлнэ.

7.8.3-р хүснэгт - Бусад цацаргалт дохионы үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хүлээн зөвшөөрөгдөх хязгаар
Нэвтрүүлэх чадлын алдаа	± 2 дБ (ихэнх тохиолдолд)
Давтамжийн алдаа	± 0.05 ppm
Фазын шуугиан	-97 дБс/Гц @ 100 kHz offset
IQ Imbalance	< 25 дБ (image rejection ratio)

7.9 Спектрийн хэтрэлтийн хязгаарыг тодорхойлох Хэмжилтийн аргачлал:**1. RRU-г PDSCH дамжуулах горимд оруулах.**

Физик уруудах шугамын хуваалцсан суваг (PDSCH) нь 5G NR (New Radio) сүлжээний хамгийн гол дохио дамжуулах суваг юм. Энэхүү сувгаар дараах мэдээлэл дамжина:

- Хэрэглэгчийн өгөгдөл (user data)
- Сүлжээний ба удирдлагын дохиоллын мэдээлэл (system & control info)
- Хуваарилах (Scheduling) болон Гибрид автомат давталтын хүсэлтийн (HARQ) холболтын мэдээлэл

RRU-г PDSCH дамжуулах горимд оруулснаар RRU-ийн өндөр давтамжийн RF ажиллагааг шалгах, дамжуулалтын чанарын дараах үзүүлэлтүүдийг хэмжих боломжтой.

- Алдааны векторын агууриг (EVM),
- Зэрэгцээ сувгийн алдагдлын харьцаа ACLR
- Зөвшөөрөгдөөгүй (Хүсээгүй) цацаргалт
- Чадлын нарийвчлал зэрэг үзүүлэлтүүдийг хэмжихийн тулд туршилтын үед PDSCH дохиог гаргана.

Давтамж хэмжигч нь RRU-ийн нэвтрүүлэгчийн гаралтын дохионы бодит давтамжийг хэмждэг өндөр нарийвчлалтай төхөөрөмж байна. Энэ нь RRU-ийн зөөгч давтамж зөв тохирсон эсэх, мөн давтамжийн хэлбэлзэл буюу алдааг тодорхойлно. Үндсэн үүрэг нь 5G RRU-ийн гарч буй зөөгчийн бодит давтамжийг идеал давтамжтай харьцуулж, хугацааны туршид давтамж хэр тогтвортой байгааг GPS-ын лавлагаа дохио-ой харьцуулан синхрончлолыг шалгана. RRU-ийн RF гаралтаас авсан дохиог дэлхийн лавлагаа цагтай харьцуулна. Давтамжийн тоо хэмжээг секундэд тоолж, бодит давтамж гаргана. RRU-ийн нэвтрүүлж буй давтамж нь 3GPP стандартын ± 0.05 ppm (parts per million) дотор байх ёстой. Жишээлбэл:

$3.5 \text{ Гц} \times 0.05 \text{ ppm} = 175 \text{ Гц}$ Иймд $\pm 175 \text{ Гц}$ -ийн хязгаарт байх ёстой.

Ингэснээр давтамж хэмжигч, спектр анализатор зэрэг төхөөрөмжөөр дараах хэмжилтийг хийнэ. Хэмжилтийн дараалал нь:

- A. RRU-ийг Test Controller-т холбох DU/BBU simulator (жишээ: Keysight, R&S) ашиглах.
- B. Зөөгч давтамж ба зурвасын өргөнийг тохируулах Жишээ: n78 зурвас, 100 МГц
- C. PDSCH дамжууллын горим идэвхжүүлэх, “Test mode”-горимд PDSCH дохионы дамжуулалтыг эхлүүлэх.
- D. Лавлагаа дохио (SSB / DMRS) тохируулж синхрончлол болон EVM хэмжилтэд ашиглах.
- E. Спектр анализатор болон давтамж хэмжигч ашиглан RF хэмжилт хийх
2. Вектор дохионы анализатор (Vector Signal Analyzer) ашиглаж дараах хэмжилтийг хийнэ:
 - EVM (IQ constellation plot)
 - ACLR (spectrum leakage)
 - SEM (mask graph)
3. Чадал хэмжигч ашиглан, нэвтрүүлэх чадлыг шалгах.
4. Давтамжийн тоолуур (Frequency counter) ашиглан давтамжийн алдааг хэмжих.

Тайлбар:

- 5G RRU-ийн зөөгч давтамжийн алдааг хэмжих шаардлагатай. RRU-ийн бодит давтамж ба нэрлэсэн давтамжийн хооронд зөрүүг буюу зөөгчийн давтамжийн хазайлт стандарт хангаж байгаа эсэхийг хэмжих. Үүний тулд “Frequency Counter” ашиглаж RRU-ийн гаргаж буй дохиог тоолж, яг бодит давтамжийг хэмждэг. Үүний тулд дараах алхмууд байна. Үүнд:
 1. Тохиргоо хийх
 - “Frequency counter”-ыг тухайн зурвасын зөөгч давтамжид тохируулна. (жишээ: n78 band ~3.5 ГГц).
 2. Холболт
 - RRU-ийн “Test port”-ын RF гаралтаас “Frequency counter” руу холбох
 - Шууд RF холбож эсвэл унтраагч ашиглаж хэмжинэ.
 3. Хэмжилт
 - “Frequency counter” бодит гарч буй зөөгч давтамжийг харуулна.
 - Жишээ нь: нэрлэсэн давтамж нь 3.500 000 000 Гц байхад хэмжсэн давтамж нь 3.500 000 015 Гц байвал давтамжийн хазайлт (алдаа) +15 Гц болно.
 4. Алдааг тооцоолох
 - $\Delta f = f_{\text{хэмжсэн утга}} - f_{\text{nominal}}$
 - Зөвшөөрөгдөх хязгаар 3GPP TS 38.104-д тодорхойлсноор ± 0.05 ppm (parts per million) хүртэл байна.

3. Давтамжийн алдааг үнэлэх

- **Жишээ:**


- Зөөгч давтамж: 3.5 ГГц
 $\pm 0.05 \text{ ppm} = 0.05 \times 10^{-6} \times 3.5 \times 10^9 = \pm 175 \text{ Гц}$ байна. Тэгэхээр 3.5 ГГц дээр “frequency counter”-ийн хэмжилт $\pm 175 \text{ Гц}$ байх ёстой.

Шаардлагатай тоног төхөөрөмж

- Frequency Counter (жишээ: Keysight 53230A, Rohde & Schwarz FSW)
- Reference Clock Source (10 МГц Rubidium эсвэл GPS disciplined oscillator)
- Attenuator, RF кабель

5G RRU → Frequency Counter ашиглан давтамжийн алдааг хэмжих ерөнхий холболтын схемийг дүрсэлбэл:

Ерөнхий холболтын схем



Зураг 7.9.1 5G RRU → Frequency Counter ашиглан давтамжийн алдааг хэмжих ерөнхий холболтын схем

5G системийн хугацааны тохируулгын алдааг хэмжих жишээ:

5G систем дэх хугацааны тохируулгын алдааг хэмжих жишээ юм. Энэ нь хэрэглэгчийн төхөөрөмж (UE) бааз станц руу илгээж буй дохио бодит хугацааны хувьд зөв тохирч байгаа эсэхийг шалгана.

- Хугацааны тохируулгын алдаа (TA Error) нь хэрэглэгчийн төхөөрөмжийн өгсөх шугамын дохионы байгуулагчуудын хооронд давхцалыг тодорхойлох.
- Хугацааны тохируулгын алдаа их байвал олон хэрэглэгч өгсөх шугамд хоорондоо мөргөлдөж, интерференц үүсгэнэ.

Шаардагдах тоног төхөөрөмж:

- 5G UE (Хэмжилтийн хэрэглэгчийн төхөөрөмж)
- gNB RRU (бааз станц)
- Протоколын анализатор Protocol Analyzer (Keysight, R&S, Viavi зэрэг)
- Шаардлагатай тохиолдолд осциллограф эсвэл дохионы анализатор

7.8.4-р хүснэгт - Жишээ хэмжилтийн үр дүн

Хэрэглэгчийн төхөөрөмжийн UE ID	Хүлээгдэж буй цаг (микросек)	Бодит цаг (микросек)	Хугацааны тохируулгын алдаа (микросек)	Шалгуур ($\pm$ микросек)	Нийцэж буй эсэх
UE_01	250	252.4	+2.4	± 3	Тийм
UE_02	370	375.8	+5.8	± 3	Үгүй
UE_03	120	118.5	-1.5	± 3	Тийм

3GPP стандартын дагуу хугацааны тохируулгын алдаа ± 3 микросекээс бага байх ёстой. (TS 38.133).

Хэмжилтийн алгоритм:

Хугацааны тохируулгын алдаа = Бодитоор хүлээн авсан хугацаа – Хүлээгдэж буй хугацаа (7.4)

Хүлээгдэж буй хугацаа: gNB-ээс хүлээгдэж буй өгсөх шугамын дохионы хүлээн авах хугацаа

График тайлбар

5G RRU - Хугацааны тохируулгын алдааны график

Энэ график нь 3 хэрэглэгчийн (UE_01, UE_02, UE_03) хувьд:

- Цэнхэр багана нь хүлээгдэж буй өгсөх шугамын дохионы ирэх хугацаа
- Улбар шар багана нь бодитоор ирсэн хугацаа
- Дээр нь харуулсан утга бол хугацааны тохируулгын алдаа

Жишээ нь, UE_02 хэрэглэгчийн дохио хүлээгдэж байснаас 5.8 микросек хожуу ирсэн тул стандартын ± 3 микросек хязгаараас хэтэрсэн, синхрончлолын асуудал үүсгэх магадлалтай.

Хугацааны тохируулгын алдаа нь өгсөх шугамын дохионы синхрончлолд заавал шалгах параметр юм. Энэ нь хугацааны хуваалттай (TDD) горимд RRU бүрийн нарийвчлалтай ажиллах үндэс болно.

7.10 5G RRU-ийн зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)

5G RRU-ийн зөвшөөрөгдөөгүй цацаргалт нь RRU нэвтрүүлэгчээс зорилтот бус давтамжууд дээр санамсаргүй эсвэл системийн шалтгаантай үүссэн дохио бөгөөд энэ нь интерференц, бусад зөвшөөрөгдөөгүй цацаргалт нь системд нөлөөлөх, эрсдэлийг үүсгэдэг.

7.10.1-р хүснэгт - Зөвшөөрөгдөөгүй цацаргалтын төрөл

Төрөл	Тайлбар
Зурвасын гаднах цацаргалт (OOB)	Сувгийн хажуугийн ойролцоох давтамжуудад үүссэн илүүдэл дохио
Хуурамч цацаргалт	Хяналтгүй, өөр хэсгийн спектрт гарсан дохио (дохионы гармоник, хувиргалтын явцад үүссэн бүтээгдэхүүн)
Гармоник дохио	Үндсэн дохионы давтамжийн үржвэр (2 ба 3-р гармоник) дохионууд

7.10.2-р хүснэгт - 3GPP стандартын шаардлага (TS 38.104 дагуу)

Үзүүлэлт	Хязгаар
RF кабель / сорилт порт ашиглан шууд хэмжиж байгаа хуурмаг цацаргалт	≤ -13 дБмВт (жишээ)
Хуурамч цацаргалт (агаарт)	≤ -30 дБмВт / 1 МГц
Зурвасын гаднах цацаргалтын (OOB) хязгаар	≤ -40 дБдБс (үндсэн дохиотой харьцсан хэмжигдэхүүн)

Хэмжих арга:

Хэмжилтийн хэрэгсэл:

- Спектр анализатор
- Чиглүүлэмж бүхий холбогч (RRU гаралтаас дохиог ялгах)
- антены чембер (Цацаргалтын хэмжилтэд)

Хэмжих алхмууд:

1. RRU-ийг PDSCH дамжуулах горимд оруулна.
2. Спектр анализатораар хэмжилт хийж, 30 МГц–12.75 ГГц хүртэл шалгана.
3. Спектрийн дээд хэмжээ, хажуугийн сувгууд, гармоник дохионууд байгаа эсэхийг шалгана.
4. Хэмжилтийн үр дүнг 3GPP стандарттай харьцуулна.
 - Үндсэн дохио (жишээ нь 3.5 ГГц) хамгийн өндөрт байна.
 - ООВ дохионууд нь үндсэн дохионы ойролцоо, гэхдээ үндсэн спектрийн гадна байрлах “илүүдэл” дохио.
 - Хуурмаг(гармоник) дохионууд 7 ГГц, 10.5 ГГц гэх мэт давтамж дээр бага хэмжээтэй харагдана.

7.10.3-р хүснэгт - Жишээ тайлан

Давтамж (ГГц)	Хэмжсэн чадал (дБмВт)	Стандарт хязгаар	Нийцэж байгаа эсэх
3.5 (Үндсэн)	+40	—	—
3.6 (Зурвасын гаднах)	-42	≤ -40 дБс	Тийм
7.0 (2-р гармоник)	-17	≤ -13 дБмВт	Тийм
10.5 (3-р гармоник)	-11	≤ -13 дБмВт	Үгүй

Зөвшөөрөгдөөгүй цацаргалт нь онцгой зөвшөөрөлтэй системд (нислэгийн радар, онцгой байдлын холбоо) интерференц үзүүлэх. Стандарт зөрчсөн тохиолдолд RRU-д сертификат олгохгүй, хууль бус гэж үзэж болно.

7.10.4-р хүснэгт - Хэмжилтийн шаардлага

Бааз станцын сувгийн зурвасын өргөн ($BW_{Channel}$)	Хажуугийн сувгийн гажилт	Хажуугийн сувгийн зөөгч	Шүүрийн зурвасын өргөн	ACLR хязгаар
5,10,15,20	$BW_{суваг}$	NR нь ижил зурвас	Square ($BW_{дамжуулах}$)	44.2 дБ
	$2 \times BW_{суваг}$	NR нь ижил зурвас	Square ($BW_{дамжуулах}$)	44.2 дБ
	$BW_{суваг}/2+2.5\text{МГц}$	5МГц E-UTRA	Square ($BW_{дамжуулах}$)	44.2 дБ
	$BW_{суваг}/2+7.5\text{МГц}$	5МГц E-UTRA	Square ($BW_{дамжуулах}$)	44.2 дБ
25,30,40,50,60,70,80,90,100	$BW_{суваг}$	NR нь ижил зурвас	Square ($BW_{дамжуулах}$)	43.8 дБ
	$2 \times BW_{Channel}$	NR нь ижил зурвас	Square ($BW_{дамжуулах}$)	43.8 дБ
	$BW_{суваг}/2+2.5\text{МГц}$	5МГц E-UTRA	Square ($BW_{дамжуулах}$)	43.8 дБ
	$BW_{суваг}/2+7.5\text{МГц}$	5МГц E-UTRA	Square ($BW_{дамжуулах}$)	43.8 дБ
$BW_{дамжуулах} = N_{RB} \times SCS \times 12\text{кГц}$, RRU эсвэл gNB-д тохируулсан сүлжээний дамжуулах зурвасын өргөнийг заасан параметр юм.				

Зөвшөөрөгдөөгүй цацаргалт нь радио дамжуулагч төхөөрөмжөөс (жишээ нь 5G RRU) зорилтот бус давтамжууд дээр гарч буй дохионууд юм. Эдгээр дохионууд нь өөр системүүдэд интерференц үүсгэж болзошгүй байдлыг харуулна.

7.10.5-р хүснэгт - Зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)-ийн төрлүүд

Төрөл	Тайлбар
Зурвасын гаднах цацаргалт (ООВ)	Үндсэн сувгийн ойролцоох (сувгийн хязгаарын гадна) дохио
Хуурамч цацаргалт	Илүү хол давтамж дээр санамсаргүй эсвэл системийн шалтгаантайгаар үүссэн дохио (Гармоникууд, интермодуляци)

7.10.6-р хүснэгт - Зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)-ийн стандарт (3GPP TS 38.104)

Үзүүлэлт	Хязгаар
----------	---------

RF кабель / сорилт порт ашиглан шууд хэмжиж байгаа хуурмаг цацаргалт	≤ -13 дБмВт (нэг сувгийн өргөнд)
Хуурамч цацаргалт (агаарт)	≤ -30 дБмВт/1 МГц
Зурвасын гаднах цацаргалт (ООВ)	≤ -40 дБс (үндсэн дохиотой харьцуулахад)

5G RRU дахь зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)-ын жишээ:

- Үндсэн дохио: 3.5 ГГц дээр байрлаж байгаа (e.g., n78 band)
- ООВ: 3.4 ГГц болон 3.6 ГГц орчимд үүсэж болох илүүдэл дохионууд
- Хуурамч цацаргалт:
 - 2-р гармоник: 7.0 ГГц
 - 3-р гармоник: 10.5 ГГц
 - Дотоод интермодуляцийн бүтээгдэхүүн (IMD бүтээгдэхүүн)

Зөвшөөрөгдөөгүй цацаргалт (UE)-ийн хэмжилт:

- Хэмжилтийн төхөөрөмж: Спектр анализатор
- RRU-ийн гаралтад шууд холбож хэмжинэ
- Шалгах диапозон: 30 МГц–12.75 ГГц

Антенны чемберийн өрөө эсвэл EMC лабораторид цацаргалтыг хэмжинэ. Олон чиглэлээс хэмжиж хамгийн их утгыг тодорхойлно. Ийнхүү Интерференцээс урьдчилан сэргийлэх шалтгаан нь:

- Онцгой байдлын холбооны системд интерференц үзүүлж болзошгүй.
- Бусад цацаргалт операторууд, системүүдийн ажиллагааг доголдуулж болзошгүй.
- Олон улсын цахилгаан соронзон зохицлын (EMC) болон 3GPP шаардлагыг зөрчвөл сертификат хүчингүй болно.

7.11 Хуурамч цацаргалт (SE)

Хуурамч цацаргалтын хэмжилтийн жишээ нь 5G RRU нэвтрүүлэгчийн стандарт хэмжилтийн нэг хэсэг болдог.

Хуурамч цацаргалт нь үндсэн дохионы зурвасаас гадуур, хол давтамжуудад үүсч буй санамсаргүй дохионууд бөгөөд тэдгээрийг 3GPP болон ITU стандартын дагуу хэмжинэ.

7.11.1-р хүснэгт - Хэмжилтийн орчин (Test Setup)

Бүрэлдэхүүн	Тайлбар
5G RRU	Хэмжилт хийх төхөөрөмж
Спектр анализатор	Дохионы чадал болон спектр хэмжих
RF Coupler/Унтраагч	Анализаторт тохирох хэмжээнд бууруулах
Туршилтын горим	PDSCН идэвхэжсэн, бүрэн зурвасын өргөний дамжуулал

7.11.2-р хүснэгт - Хэмжих давтамжийн хүрээ

Бүс	Цараа (жишээ)
1	9 кГц – 30 МГц
2	30 МГц – 1 ГГц
3	1 ГГц – 12.75 ГГц (эсвэл 26.5 ГГц)

7.11.3-р хүснэгт - Жишээ хэмжилтийн үр дүн

Давтамж (ГГц)	Хэмжсэн чадал (дБмВт)	Стандарт хязгаар	Нийцэж байгаа эсэх
7.0 (2-р гармоник)	-17	≤ -13 дБмВт	Тийм

10.5 (3-р гармоник)	-11	≤ -13 дБмВт	Үгүй
12.5 (хуурамч цацаргалт)	-14	≤ -13 дБмВт	Тийм

Спектрийн тайлбар:

- 3.5 ГГц – үндсэн дохио (жишээ: n78 зурвас)
- 7.0 ГГц, 10.5 ГГц – гармоник дохио
- 12.5 ГГц – бусад зөвшөөрөгдөөгүй цацаргалт системийн үүсгэсэн интермодуляцийн дохио
- -13 дБВт шугам – 3GPP стандартын хүлцэх дээд хязгаар

Дүгнэлт:

- Хуурамч цацаргалт нь системийн гүйцэтгэлд шууд хамааралтай.
- RRU-гийн бүх дамжуулалын нөхцөлд энэ шалгуурыг хангах шаардлагатай.
- Хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, чадлын өсгүүрийн тохиргоо, долгионы хэлбэрийн тохиргоо хийх шаардлагатай.

5G RRU-ийн интермодуляцын хэмжилт нь радио дохионы гармоник бус нөлөөллөөс үүсэх хуурамч дохионуудыг илрүүлж, RRU-ийн RF гүйцэтгэлийг шалгахад зайлшгүй шаардлагатай.

7.12 Интермодуляц

Интермодуляц нь хоёр буюу түүнээс дээш тусдаа дохио систем дотор харьцаж (шугаман бус) байснаар шинэ, зөвшөөрөгдөөгүй давтамжийн дохионууд үүсэх үзэгдэл юм.

Жишээ нь:

- Хоёр дохио: $f_1 = 3.5$ ГГц, $f_2 = 3.6$ ГГц
- Интермодуляцын бүтээгдэхүүн:
- $2f_1 - f_2, 2f_2 - f_1 \rightarrow 3.4$ ГГц гэх мэт

Интермодуляцыг хэмжих алхмууд:

- Нэгдүгээр шат: Хоёр дохиог үүсгэх
 - $f_1 = 3.5$ ГГц
 - $f_2 = 3.6$ ГГц
 - Дохионы түвшин: -20 дБмВт
- Хоёрдугаар шат: RRU эсвэл DUT-д дохионуудыг оруулах
 - Модуляц ашиглахгүй, CW (үргэлжилсэн дохио)
- Гуравдугаар шат: Spectrum Analyzer-аар дараах давтамжууд дээр шалгах
 - $f_3 = 2f_1 - f_2$
 - $f_4 = 2f_2 - f_1$
 - $f_5 = f_2 - f_1$ (ялгаатай байгуулагчууд)

7.12.1-р хүснэгт - Интермодуляцын хэмжилтийн үр дүн

Давтамж (ГГц)	Интермодуляцын төрөл	Хэмжсэн чадал (дБмВт)	Стандарт хязгаар	Нийцэж байгаа эсэх
3.4	$2f_1 - f_2$	-42	≤ -40 дБмВт	Тийм
3.7	$2f_2 - f_1$	-38	≤ -40 дБмВт	Үгүй

3GPP болон FCC/ETSI-ийн ихэнх шаардлагад Интермодуляцын дохио -40 дБмВт-аас бага байна.

- Интермодуляцын бүтээгдэхүүнүүд нь өөрийн болон хөрш сувгуудад нөлөөлж, интерференц үүсгэх, үйлчилгээний чанарыг (QoS) бууруулах, гардварын алдаа үүсгэдэг.
- Зөөгч нэгтгэл (SA), MIMO зэрэг системүүдэд илүү нөлөөлнө.

Дүгнэлт:

Интермодуляцын хэмжилт нь RRU болон антены RF хэлхээний шударга байдал, шугаман чанарыг шалгах шалгуур болно. Хэт их интермодуляц илэрвэл:

- Чадлын өсгүүрийн гажуудал (PA distortion)
- Шүүрийн алдагдал (Filter leakage)
- Антены холболт (Antenna coupling)
- Аналог хэлхээнд шугаман бус байдал

5G RRU Интермодуляцын хэмжилтийн тайлан:

7.12.2-р Хүснэгт - 5G RRU-ийн Интермодуляцын хэмжилтийн загвар

№	Давтамж (ГГц)	Интермодуляцын төрөл	Хэмжсэн чадал (дБмВт)	Стандарт хязгаар	Нийцэл	Хэмжилтийн тоо	RRU загвар
1	3.4	$2f_1 - f_2$	-42	≤ -40 dBm	Тийм	2025-04-16	RRU-X1000
2	3.7	$2f_1 - f_2$	-38	≤ -40 dBm	Үгүй	2025-04-16	RRU-X1000

7.13 5G RRU-ийн түлхүүр RF үзүүлэлтүүдийг цуурайгүй камер буюу радио долгионы нөлөөллөөс бүрэн тусгаарлагдсан орчин буюу чемберт хэмжих**Цуурайгүй камер буюу чембер:**

- Радио долгионы тусгалыг шингээдэг хөөсөөр бүрсэн, тусгай зориулалтын Хэмжилтийн өрөө юм.
- Төхөөрөмжөөс цацарсан Радио давтамжийн цацаргалтын гүйцэтгэл буюу үзүүлэлтийг шалгах орчин болно.

Стандартууд:

- 3GPP TS 38.141-2 – NR Base Station Conformance Testing: Part 2 (Radiated)
- 5G бааз станц (RRU)-ийн OTA (Over-the-Air) болон beamforming шалгуурын стандарт.
- ETSI TR 103 585 – RF Performance for 5G Base Stations (OTA)
- RRU-ийн цацралт, чиглэлт, үр ашиг зэрэг хэмжилтийг чемберт гүйцэтгэх аргачлал.
- IEC 61000-4-3 / 61000-4-20
- ЭМС (EMC) сорилт хийх анхны үндсэн зааврууд. Anechoic chamber хэрэглэсэн хэмжилтийн үндэслэлтэй.

7.13.1-р хүснэгт - 5G RRU-г Чемберт хэмжих түлхүүр үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тайлбар
Radiated Spurious Emissions (RSE)	RRU-аас хүсээгүй давтамжууд дээр гарсан цацаргалт
EIRP / TRP (Effective Radiated Power / Total Radiated Power)	Үр ашигтай цацаргалтын чадал/ Нийт цацаргаж буй бодит чадал
Beamforming Performance	Цацраг хэлбэржүүлэг чиглэлүүдээр дохио хэр цацагдаж байгааг шалгах
Field Uniformity, Far-field gain	RF талбайн жигд байдал, хол зайн орны өсгөлт

7.13.2-р хүснэгт - Хэмжилтийн орчин

Төхөөрөмж	Зорилго
Цуурайгүй камер	Цацралтын тусгалгүй орчин
Тохируулгатай	DUT (RRU)-г 360 градус эргүүлэх
Антен (V/H)	RF хүлээн авах / шинжлэх
Спектр анализатор / VSA	Доод түвшний дохио хэмжих
Үндсэн зурвасын спектр (BBU Sim)	RRU-г идэвхжүүлэх, дохио дамжуулах горимд оруулах

Хэмжилтийн жишээ:**Хуурамч цацаргалтын Хэмжилт:**

- RRU-г 3.5 ГГц дамжуулах горимд оруулна.
- Спектр анализатор ашиглан 30 МГц – 12.75 ГГц хүрээнд цацарсан дохионуудыг шалгана.
- Стандарт хязгаар: ≤ -30 дБмВт/1 МГц

Цацаргасан нийт чадал (TRP):

- RRU-ийн 3D чиглэлүүдэд эргүүлж, нийт энергийн нийлбэрийг тооцно.
- “Цацраг хэлбэржүүлэгч” ашиглаж байгаа тохиолдолд SSB дээр байна.
- Стандарт: TS 38.141-2 6.2-р хэсэг

Цацрагийн загвар ба өсгөлт (Beam Pattern & Gain):

- Антену хувьд:
 - Үндсэн дэлбээ болон дэд оройнуудыг шалгах.
 - Азимут болон өндийх өнцгийн чиглэлүүдэд анализ хийх.
- RRU цацраг хэлбэржүүлэгч нь 3GPP-ийн $\pm 60^\circ$ -ийн сектор дотор 3–8 цацраг бүхий чиглүүлэмжтэй байна.


Тайлангийн бүтэц:**RRU Radiated Test Report (Цуурайгүй чемберт)**

- DUT: 5G RRU (Model X1000)
- Давтамж: 3.5 ГГц (n78)
- Цуурайгүй чемберийн орчин
- Хэмжилтийн стандарт: 3GPP TS 38.141-2


7.13.3-р хүснэгт - Хэмжилтийн үр дүнгийн жишээ

Үзүүлэлт	Хэмжсэн утга	Стандарт хязгаар	Нийцэж байгаа эсэх
Цацруулсан хуурамч цацраг	-34 дБм	≤ -30 дБм	Тийм
Нийт цацаргалтын чадал	37 дБм	≥ 36 дБм	Тийм

Хамгийн их өсгөлт (0° Az)	8.5 дБи	≥ 8 дБи	Тийм
Хажуугийн дэлбээний төвшин	-17 дБ	≤ -15 дБ	Тийм



7.13.1-р зураг - 5G RRU-ийн e.i.r.p буюу нийт цацаргаж буй чадлыг хэмжих



7.13.2-р зураг - 5G RRU-ийн цацраг хэлбэржүүлэлтийн чиглүүлэмж.

RRU-ын 0° – 360° чиглэлд дохионы цацаргалт. Үндсэн дэлбээ нь хамгийн их өсөлттэй чиглэл бөгөөд ихэвчлэн хэрэглэгч рүү чиглэнэ. Хажуугийн дэлбээ нь бусад хүсээгүй цацаргалт чиглэл рүү сул дохио цацагдаж байгааг илтгэнэ.

7.13.4-р хүснэгт - 5G RRU Хэмжилтийн загвар

№	Хэмжилтийн төрөл	Хэмжсэн утга	Хүлээгдэж буй стандарт	Нийцэл	Хэмжилтийн огноо	RRUзагвар
1	Хамгийн их нэвтрүүлэх чадал (Tx Power)	40 дБm	$\leq \pm 2$ дБ	Тийм	2025-04-17	RRU-X1000
2	EVM (256QAM)	2.58%	≤ 3.5 %	Тийм	2025-04-17	RRU-X1000

3	ACLR (± 1 RB)	47 дБ	≥ 45 дБ	Тийм	2025-04-17	RRU-X1000
4	SEM	Passed	Pass	Тийм	2025-04-17	RRU-X1000
5	RSE (Spurious)	-34 дБm	≤ -30 дБm	Тийм	2025-04-17	RRU-X1000
6	TRP	37.5 дБm	≥ -36 дБm	Тийм	2025-04-17	RRU-X1000
7	Цацрагийн өсгөлт	8.2 дБi	≥ 8 дБi	Тийм	2025-04-17	RRU-X1000

Спектрийн анализаторын RBW (1 МГц) болон VBW (3 МГц) тохиргоо нь 5G NR зурвасын өргөнд (BWP)-ийн анализ хийхэд ашиглах боломжтой байх. Энэ тохиолдолд антен болон бага шуугианы өсгөгчийн (LNA) өсгөлт, кабелийн алдагдлуудыг тооцоолон ерөнхий хүлээн авсан чадлыг үнэн зөв тодорхойлох.

7.13.5-р хүснэгт - 5G RRU-ийн e.i.r.p болон спектрийн цацаргалтыг хэмжих

Асуудал	Тайлбар
Давтамжийн цараа	5G RRU нь Sub-6 ГГц болон mmWave (>24 ГГц)-д ажилладаг. Иймд антен болон LNA нь таны 5G зурваст тохирох эсэхийг шалга.
Антен ба бага шуугианы өсгөгчийн шаардлага	5G-н хэмжилт хийх бол өндөр өсгөлт бүхий, цацраг хэлбэржүүлэлтийг дэмждэг антен шаардлагатай.
Хэмжилтийн зай r	Алсын радио нэгж (RRU)-н e.i.r.p өндөр тул safety distance болон чөлөөт орчны замын алдагдлыг зөв тооцох хэрэгтэй.
Тохируулга	Бүх төхөөрөмжүүд (antenna, cable, LNA)-ийг зөв калибровка хийх шаардлагатай.
Чиглүүлэмжтэй цацраг	Хэрэв алсын радио нэгж (RRU) нь цацраг хэлбэржүүлэлт ашиглаж байвал, хамгийн өндөр цацаргалттай чиглэлийг хэмжих ёстой.

Цацраг хэлбэржүүлэлт болон олон оролт, олон гаралтай (MIMO) сувагт хэмжилтийн нөхцөлийг сайтар зохицуулна.

7.14 ЦУУРАЙГҮЙ ЧЕМБЕРТ ХИЙХ 5G RRU ХЭМЖИЛТ

5G RRU – Цуурайгүй чемберт хэмжих аргачлал:

Зорилго:

Энэхүү аргачлалын зорилго нь 5G RRU төхөөрөмжийн цацаргалтын гүйцэтгэлийг цуурайгүй (anechoic) камерт үнэлэхэд оршино. Хэмжилт нь олон улсын стандартуудын дагуу гүйцэтгэгдэж, нэвтрүүлэх чадал, цацаргалтын хязгаар, болон цацраг хэлбэржүүлэлтийн чиглэлийн гүйцэтгэлийг хэмжихэд чиглэнэ.

Ашиглагдах стандартууд:

- 3GPP TS 38.141-1: NR Base Station conformant test
- ETSI EN 301 908-13: IMT радио системийн RF шаардлага
- ITU-R SM.329 / SM.1541: Spurious болон unwanted emissions хязгаар
- FCC Part 30 (шаардлагатай тохиолдолд)

Хэмжилтийн тоног төхөөрөмж ба орчны шаардлага:

- Цуурайгүй камер (чембер хэмжээ) : $\geq 5 \text{ м} \times 5 \text{ м} \times 3 \text{ м}$
- Дохио хүлээн авагч антеннтай зай: 3–5 м
- Камерын ханын шингээлт: ≥ 60 дБ
- Turntable болон antenna positioner ашиглах боломжтой байх

- Температур: 20–25°C, Чийг: ≤ 60%

Хэмжилтийн алхмууд:

1. DUT (RRU)-г камерын дунд төв байрлалд суурилуулна.
2. Хүлээн авагч антеныг 3–5 м-ийн зайд байрлуулна.
3. DUT (RRU)-ийг бүрэн асааж, TDD горимд ажиллуулна.
4. Хэмжилтийн үзүүлэлт тус бүрд тохирох хэмжилтийн дарааллыг гүйцэтгэнэ:
 - Нэвтрүүлэх чадал Tx Power (EIRP)
 - ACLR (Adjacent Channel Leakage Ratio)
 - Хуурмаг цацаргалт
 - Спектрийн цацаргалтын маск (SEM)
 - Цацраг хэлбэржүүлэх загвар (хэмжих өнцөг бүрээр)
5. Үр дүнг тэмдэглэж, стандарттай харьцуулан үнэлгээ өгөх

Жишээ тохиргоо

- DUT (RRU)-: Гадна 5G RRU (n78, 3.5 ГГц)
- Tx bandwidth: 100 МГц
- Цацраг хэлбэржүүлэлт: $\theta = -30^\circ$ to $+30^\circ$
- Хэмжих үзүүлэлтүүд: EIRP, spurious, ACLR, SEM
- Горим: TDD, Бүрэн чадал

6. Үр дүнгийн боловсруулалт

7.14.1-р хүснэгт - Хэмжилтийн үр дүнгийн загвар

Хүснэгт	Хүснэгт	Хүснэгт	Хүснэгт
EIRP	43.2 дБм	≤ 44 дБм	Зөвшөөрөгдөх түвшинд
ACLR	47.5 дБ	≥ 45 дБ	Хажуу сувгийн хязгаар хангасан
Spurious Emission	-48 дБм	≤ -43 дБм	Нийцсэн
SEM @ ±10 МГц	-27 дБм/МГц	≤ -25 дБм	Хязгаар ойролцоо

5G RRU – Цуурайгүй чемберт хэмжсэн жишээ тайлан:

Энэхүү баримт бичиг нь 5G RRU-ийн цуурайгүй чемберт хийдэг хэмжилтийн шаардлага, стандарт, техникийн нөхцөл болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан болно. Хэмжилт нь олон улсын стандартуудын дагуу 5G RRU-ийн нэвтрүүлэх чадал, цацаргалтын хязгаар, болон цацраг хэлбэржүүлэлтийн чиглэлийн гүйцэтгэлийг үнэлэх зорилготой.

Ашиглагдах стандартууд:

- 3GPP TS 38.141-1 – NR Base Station conformant test
- ETSI EN 301 908-13 – IMT системийн радио дамжуулах төхөөрөмжийн шалгуур
- FCC Part 30 – U.S. flexible use services
- ITU-R SM.329, SM.1541 – Spurious болон unwanted emissions хязгаар

Хэмжилтийн орчны шаардлага:

- Chamber хэмжээ: $\geq 5 \text{ м} \times 5 \text{ м} \times 3 \text{ м}$
- Reflections: -60 дБ буюу түүнээс баг
- Антентай зай: 3–5 метр
- RRU нь turntable эсвэл elevation механизмаар тохируулах боломжтой
- Орчны температур: 20–25°C, харьцангуй чийг ≤ 60%

7.14.2-р хүснэгт - Хэмжилтээр хэмжих үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тайлбар	Холбогдох стандарт
Цацаргалтын нэвтрүүлэх чадал (EIRP)	Антеннаар цацарагж буй нийт чадал	3GPP TS 38.141-1
Хуурмаг цацаргалт	Хүсээгүй, давтамжийн хүрээнээс гадуурх цацаргалт	ITU-R SM.329
ACLR	Хажуу сувгийн алдагдлын харьцаа	3GPP TS 38.104
SEM	Спектрийн цацаргалтын маск	3GPP TS 38.141-1
Beamforming Pattern	Цацаргалтын өнцгийн зураглал	3GPP OTA

Жишээ Хэмжилтийн тохиргоо:

- DUT: Outdoor 5G RRU (n78, 3.5 ГГц)
- Нэвтрүүлэх зурвасын өргөн: 100 МГц
- Антентай зай: 3.5 м
- Цацраг хэлбэржүүлэлтийн хэмжилт: $\theta = -30^\circ$ to $+30^\circ$, every 5°
- Хэмжигдэх үзүүлэлтүүд: EIRP, хуурмаг цацаргалт, ACLR, SEM
- Үйлдлийн горим: TDD, бүрэн чадал

Хэмжилтийн зохион байгуулалтын схем:

Доорх схем нь цуурайгүй чемберийн хэмжилтийн ерөнхий зохион байгуулалтыг харуулж байна. RRU-ээс цацагдаж буй дохиог хүлээн авагч антен нь тохирсон зай, өнцөгт байрласан байна.

ХАВСРАЛТ 1

RRU-д зориулсан хэмжилт, баталгаажуулалт; тохиромжтой байдал ба гүйцэтгэлийн хэмжилтийн техникийн тодорхойлолт


RRU нь нээлттэй Радио хандалтын сүлжээг (OpenRAN) нэвтрүүлэхэд чиглэсэн хос зурвастай. Энэ загвар нь нээлттэй Радио хандалтын сүлжээнд чадлын хоёр зурвасын радио нэгжүүдтэй холбоотойгоор цахилгаан болон механик асуудлыг шийдвэрлэх шийдлүүдтэй.

Crest Factor Reduction (CFR) нь Долгионы хамгийн их чадлыг бууруулж, чадлын өсгүүрийг (PA) илүү шугаман горимд ажиллах нөхцөл бүрдүүлэх дохио боловсруулалтын (DSP) арга юм.

- Пик ачааллыг бууруулснаар, энергийн үр ашиг сайжирч, хуурмаг цацаргалт буурч, спектрийн ашиглалт сайжирна.

Тоон урьдчилан гажуудал (Digital Pre Distortion-DPD) болон CFR буюу долгионы чадлын харьцааг хамгийн их утгаас дундаж руу бууруулах PAPR-ын нэгэн адил арга юм. CFR нь OFDM-ийн ашиглах үед уг системийн чадлын өсгөгчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зориулагдана.

Одоо ашиглаж байгаа 4G радио хандалтын сүлжээний (PXC) бүтэц нь үндсэндээ шилэн кабелиар эсвэл утасгүй холбоогоор холбогдсон бааз станцад (eNB) суурилдаг. Төв оффисоос үндсэн сүлжээнд холбогдох холболтыг Х.1.1.-р зурагт үзүүлсэн. Бааз станцад антен, RRU болон дохио боловсруулахад зориулсан үндсэн зурвасын хэсэг (BBU) байна. RRU болон үндсэн зурвасын бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондох холболтыг BS-ээс үндсэн сүлжээнд холбох холболтоос ялгахын тулд ихэвчлэн өмнөх холболт гэнэ.



Х.1.1-р зураг - Уламжлалт радио хандалтын сүлжээний (PXC) тархмал бүтэц


1. Төвлөрсөн ба виртуал Радио хандалтын сүлжээ (PXC)

Одоо ашиглаж байгаа 4G сүлжээний суурилуулалтад том хэмжээтэй биш ч Төвлөрсөн Радио хандалтын сүлжээний RAN (C-RAN) бүтцийг Х.1.2.- р зурагт тайлбарласан.

Виртуал Радио хандалтын сүлжээ RAN (V-RAN) бүтцийг Х.1.3 - р зурагт үзүүлсэн. Ирээдүйн 5G хөдөлгөөнт холбооны операторуудын бүтэц нь 4G хандалтаас ялгаатай, Виртуал Радио хандалтын сүлжээний (V-RAN) шийдэлд суурилсан байна.

2. C-RAN

Төвлөрсөн Радио хандалтын сүлжээний C-RAN шийдлүүд нь BBU-г зохих төвлөрсөн байршилд шилжүүлэх замаар бааз станцын (BS) функцууд нь Х.1.2. - р зурагт үзүүлсний дагуу хуваагдана. BBU-үүд нь төвлөрсөн байхаас гадна зориулагдсан хандалтын сүлжээний гүйцэтгэлийг оновчтой болгохын тулд өөр хоорондоо уялдаа холбоотой.



Х.1.2-р зураг - C-RAN ба уламжлалт бүтэц (“front-hauling” өмнөх)

Үүний үр дүнд бааз станцыг (BS) хялбаршуулж, зөвхөн RRU-г агуулсан болно. BBU болон RRU нь холбооны үйлдвэрлэгчдэд тавигддаг тусгай шаардлагуудыг хэвээр хадгална. Төвлөрсөн байршилд BBU-г нэгтгэх нь үйл ажиллагааны, техник хангамжийн болон спектрийн үр ашгийн дараах давуу талуудтай:

- Суурилуулалт нь илүү хялбар, илүү хурдан бөгөөд жижиг RRU-уудыг ашигласнаар суурилуулалтын талбай багасна;
- Антен ба RRU хоорондын коаксиаль фидерээс үүсэх алдагдлаас зайлсхийх замаар тэжээлийн алдагдлыг бууруулна.
- BBU нь Төв оффисын UPS болон бусад хүсээгүй цацаргалтаас хамгаалж, нөөц цахилгаан тэжээлээр хангагдах хүртээмж нь сайжирсан.
- Хамтдаа байрлах BBU-уудын хоорондох протоколын хоцролт маш бага тул илүү их багтаамжийг хангах, радио болон үүрийн гүйцэтгэл сайжирсан;

3. Виртуал Радио хандалтын сүлжээ V-RAN

V-RAN-ы бүтцийг Х.1.3-р зурагт үзүүлсэнчлэн Мэдээллийн технологийн төвүүдэд одоо байгаа дүрэм журам, процессуудыг ашиглан BBU функцуудыг серверийн ерөнхий төхөөрөмжийн программ хангамжаар гүйцэтгэнэ.


Программ хангамжид суурилсан шийдэлд шилжихийг ерөнхийдөө сүлжээний функцийн виртуалчлал “Network Functions Virtualization (NFV)” гэж нэрлэнэ. V-RAN нь дамжууллын хөрөнгө оруулалтыг хязгаарлах (ихэвчлэн Ethernet дээр суурилсан) болон мэдээллийн технологийн технологи, NFV шийдлүүдийг ашиглахад илүү үр ашигтай өмнөх технологи нэвтрүүлснээр C-RAN-ийн давуу тал дээр суурилж, өргөтгөх чадвар, зардал, уян хатан байдлын хувьд давуу талуудтай. Энэ нь үүрэн холбооны сүлжээний үйлчилгээний платформыг (NSP- Network Service Platform) ажиллуулах боломжийг олгосноор үүлэн тооцооллын платформууд мэдээллийн технологийн орчинд ажилладагтай адил “үйлчилгээ”-г гүйцэтгэдэг. NSP нь статистик хандалтын аргыг ашигласнаар бага, үр ашигтайгаар ижил үүргийг гүйцэтгэх боломжтой. Бүрэн төвлөрсөн BBU арга нь BBU-ийн тооцооллын ихээхэн хэсгийг бүрдүүлдэг доод давхаргын боловсруулалтыг тусгай техник хангамжаар гүйцэтгэх харилцан уялдааг дээд зэргээр хангадаг. Цаашид багтаамжийг өргөтгөхөд радио үүрүүдийг ашиглан макро, мини болон пико төрлийн жижиг үүрүүдийг ч V-RAN- тай холбож холимог сүлжээг үүсгэснээр, зохицуулалтын давуу талыг хадгалах болон үзүүлэлтүүдийг оновчлох боломжтой. Ийм байдлаар Төв оффисууд дата төвийн чиг үүргийг хадгалдаг. Гэсэн хэдий ч хэт өндөр найдваржилттай бага хоцролттай URLLC зэрэг зарим тусгай хэрэглээний хувьд дата төвүүд нь RRU-тай ойрхон байх ёстой. Ийм тохиолдолд олон хандалттай захын тооцоолол “Multi-access Edge Computing” гэсэн нэр томъёог ашигладаг.

Ашигласан шийдлүүд нь хөдөлгөөнт холбооны операторуудын сонголт байх боловч RRU-г байгуулах гэрлийн багана, гэрлэн дохио, барилга зэрэг нийтийн дэд бүтцийг хангах ёстой.

4. gNB (CU/DU) ба RRU / Remote Radio Head (RRH) хоорондын интерфейс

“RRU-д дотоод дохио дамжуулах холбоо, бага хоцролт, зурвасын өргөн их, бодит хугацааны дохио боловсруулалт шаардагдана.

Энэ нь үндсэн зурвасын нэгж (BBU), түүнд холбогдсон антенуудыг хооронд нь холбох, тэдгээр BBU-аас RRU-д мөн RRU-ээс BBU-д мэдээллийн урсгалыг цуглуулах болон түгээх сүлжээ юм. Үндсэн зурвасын нэгж (BBU) болон алсын удирдлагатай радио толгой (RRH) хооронд радио хандалтын сүлжээний дэд бүтцийг шилэн кабелиар ихэвчлэн холбодог ч тодорхой нөхцөлд утасгүй холболт байдаг.



Х.1.3-р зураг - V-RAN ба холболтын интерфейсын бүтэц

Технологийн сонголт, протокол, BBU-ийн янз бүрийн функциональ хуваагдлын байршил нь хөдөлгөөнт холбооны операторуудын сонголт байх ба дараах шалгуурт тулгуурлана.

- Тусгай хэрэглээний тохиолдол;
- BBU болон RRU хоорондын зай;
- Шаардлагатай зурвасын өргөн;
- Хоцролтын хязгаар;
- Үйлчилгээний алдагдалд үзүүлэх нөлөө.

Холболтын хэд хэдэн боломжууд байдаг - одоогийн байдлаар хамгийн түгээмэл шийдэл нь CPRI (Common Public Radio Interface) юм.

C-RAN бүтцэд энэ холболт нь BBU болон RRU хоорондох дохиог дамжуулна. Тиймээс C-RAN бүтэц нь олон Гигабит радио дохиог бодит хугацаанд дамжуулахын тулд оптик сүлжээг шаарддаг.

V-RAN бүтцэд дохионы боловсруулалтын нэг хэсгийг RRU-д гүйцэтгэдэг бөгөөд энэ нь өмнөх сүлжээнд тавигдах шаардлагыг бууруулдагас мм долгионы шийдлүүдийг авч үзэх боломжийг олгодог. Хоцролтод тавигдах зөвлөмжийг мөрдөхийн тулд өмнөх идэвхгүй холболтын хоорондын зай 10-80 км хэтрэхгүй байх ёстой. Хөдөлгөөнт төхөөрөмжид нэмэлт хоцролт үүссэн тохиолдолд энэ зайг багасгахад хүргэнэ.

Үндсэн зурвасын болон радио давтамжийн модулиуд нь шилэн кабелийн холболтоор, зарим тохиолдолд тусгайлсан радио гүүрээр холбогдож, радио дохиог дамжуулах, сэргээх зорилго бүхий интерфейстэй.

Радио спектрийн 20 МГц-ийн зөөгч бүр хамгийн багадаа 2.5 бит/сек хурд шаардана. Мөн C-RAN-д 100 мкс, V-RAN-д 1 мс хоцролтын хязгаарлалтууд байна.

MIMO техникийг ашиглах үед энэ багтаамжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Учир нь олон үүрийн болон олон давтамжийн бааз станцын сайтууд нь маш өндөр дамжууллын багтаамжийг шаардах үед анх өөр контекст хэрэглээнд зориулагдсан нийтлэг радио интерфейстэй (CPRI) үед 5G радио хандалтын сүлжээг (RAN) үр ашигтайгаар хэрэгжүүлэхэд төвөгтэй болдог.

ТАЙЛБАР: IEEE Next Generation Fronthaul Interface (IEEE 1914) ажлын хэсгээс тодорхойлсон шинэ интерфейс хөгжүүлсэн eCPRI-ийг санал болгосон.

Судалгааны болон загварчлалын үйл ажиллагаа нь BBU болон RRU хоорондын хуваагдлыг дамжууллын багтаамжид ойролцоо утгад хүргэх, зурвасын өргөний шаардлагыг багасгах, хоцролтыг (мсек) бууруулахын тулд функциональ хуваагдлыг хамгийн үр ашигтай тодорхойлоход чиглэсэн байдаг.

Хамгийн сайн функциональ хуваах шийдлүүд нь Ethernet-д суурилсан дамжуулалт ашиглах замаар хөдөлгөөнт холбооны сүлжээний өндөр гүйцэтгэлийг хангадаг. Энэ нь сүлжээний функцүүдийн виртуалчлалын (NFV) бүтцэд ашигладаг, Ethernet-д суурилсан C-RAN-аас V-RAN руу шилжих шилжилтийг дэмждэг.


X.1.1 RRU суурилуулах интерфейс ба жишээ

Дээд талд суурилуулсан фланцын интерфейс

RRU-г дээд байрлалд суурилуулах гэрлийн тулгууруудын жишээг Зурагт X.1.1.1 - д үзүүлэв. Бэхэлгээний интерфейсийг гэрлийн баганын дээд талд байрлуулж болно. Бүсэлхийн гурван нүх нь гэрлийн баганын тохижилтын бүрхэвчтэй холбогдож, доторх RRU-ийн хэвтээ өнцгийг тохируулна. Физик фланцын интерфейсийн ердийн хэмжээсийг Зураг X.1.1.2-т үзүүлэв, фланцын дотоод диаметр нь 60 мм-ээс багагүй байх ёстой бөгөөд энэ нь RRU-ийн цахилгаан кабель болон дотор талд оптик утсанд хангалттай зайг нөөцлөхөд тохиромжтой. Гэсэн хэдий ч дээд физик фланцын интерфейсийн бодит хэмжээсийг бүхэл бүтэн гэрлийн баганын дизайны дагуу тодорхойлох шаардлагатай.



X.1.1.1-р зураг - RRU-уудыг гэрлийн тулгуурын дээд байрлалд суурилуулсан жишээ



1-фланц 2-шураг 3-бэхэлгээ
Х.1.1.2-р зураг - Фланцын интерфэйсийн хэмжээс

Х.1.2 RRU Хажуу байрлалд суурилуулсан интерфэйс

RRU суурилуулах өөр нэг байрлал нь гэрлийн баганын хажуу талд байна. Ийм шийдлийг ихэвчлэн хамрах хүрээг тусгайлан чиглүүлэх, эсвэл гэрлийн баганын хэлбэр нь RRU-г дээд байрлалд байрлуулахыг зөвшөөрөхгүй тохиолдолд Х.1.2.1-р зурагт үзүүлснээр хийнэ. RRU хажуу талд суурилуулсан интерфэйсийг Х.1.2.2-р зурагт үзүүлэв. Өрөмдлөгийн нүхний тохирох диаметр нь 20 мм бөгөөд RRU-ийн кабель ба утаснуудыг гэрлийн баганын дотоод хэсгээр дамжуулах боломжтой. Өрөмдлөгийн цооног нь RRU-г суурилуулсны дараа ус нэвтэрдэггүй, зэврэлтээс хамгаалах хамгаалалтыг шаарддаг.



Х.1.2.1-р зураг - RRU-ын гэрлийн тулгуурын хажуу байрлалын жишээ




Х.1.3 RRU-ын өгөгдлийн холболт

Өгөгдлийн холболт - өмнөх болон завсрын дамжуулах сүлжээ

Гэрлийн баганад байрлуулсан RRU нь 50-аас 200 метрийн радиус бүхий хамрах хүрээтэй үүрийг үүсгэнэ. Эдгээр RRU-ууд нь жижиг макро үүрийн 100-аас 500м радиус бүхий хүрээг хамарна. Гэрлийн баганад байгаа BBU-г RRU-тай холбох өгөгдөл дамжуулах холболтыг зураг Х.1.3.1-т үзүүлсний дагуу хийнэ. Оптик шилэн кабелийг цэгээс цэгт (PtP), цэгээс олон цэгт (PtMP) эсвэл өмнө нь ашигласан технологийг ашигладаг. Нийтийн нийтлэг радио интерфэйсийн сайжруулсан хувилбар (eCPRI) эсвэл түүнтэй адилтгах шийдлийг ашиглан төхөөрөмжийг каскад буюу дараалсан холболтыг хийнэ.

BBU-д антенаас кабелиар холбогдсон мм долгионы (mmWave) агаарын интерфэйсын өмнөх технологи.

BBU-д кабелиар холбогдсон дундын холболттой антенаас мм долгионы буюу агаарын интерфэйс нь “Fronthaul” буюу үндсэн зурвасын нэгж (BBU) болон алсын зайн радио толгой (RRH) хоорондын радио хандалтын сүлжээний (RAN) дэд бүтэц шилэн кабелиар холбогдоно. BBU нь “backhaul” сүлжээнд холбогдох боломжийг олгодог. Энэ нь төвлөрсөн байршилд суурилуулсан болон олон RRU-д үйлчилгээг үзүүлэх боломжтой.



Х.1.3.1-р зураг - BBU болон RRU хоорондын өгөгдлийн холболт

Шилэн кабелиар (Зураг Х.1.3.1 -д үзүүлснээр) холбосон холболт хамгийн их багтаамж, өргөтгөх чадварыг санал болгодог боловч агаарын замыг ашиглах боломжгүй бол өгөгдөл болон цахилгаан хангамжийн кабелийн аль алинд нь бага зэрэг сувагчлал шаардлагатай. Одоо байгаа газар доорх замууд нь Мобайл сүлжээний операторт (MNO) шаардлагатай хэмжээг хязгаарладаг. mmWave шийдлүүд (Зураг Х.1.3.2-д үзүүлсний дагуу) суурилуулах, ашиглах явцад үүсэх хүндрэлээс зайлсхийхийн тулд суурин өгөгдлийн кабелийн суурилуулалт ашигладаг ч тухайлбал BBU болон RRU-ын антены суурилуулалтад агаарын замчлал ашиглах боломжгүй бол тэжээлийн кабель татах зэрэг нэмэлт ажиллагааг шаарддаг.

BBU болон RRU хоорондын дамжууллын үзүүлэлт нь мод, бороо, манан, хоорондын зай, цас, хэт их салхины улмаас гэрлийн баганын хэлбэлзлээс үүссэн дохионы алдагдлаар тодорхойлогдоно.

Цахилгаан хангамж


RRU-д өгөгдөл дамжуулах аргаас үл хамааран RRU бүр нь цахилгаан хангамжийг шаардана. Энэ нь Х.1.3.2-д заасан гэрэл болон мэдрэгчийн электроникийг дэмжихийн тулд гэрлийн баганын тэжээлийн эх үүсвэрээс тусдаа байх ёстой. Энэ тусгаарлалт нь гэрлийн баганын засвар үйлчилгээ, эвдрэл нь 5G сүлжээний үйлчилгээний тасралтгүй байдалд нөлөөлөхгүй байх нь чухал.

Бэлэн байдал

Боломжтой байдлын хамгийн эхний зүйл бол тухайн хотын гэрлийн багана нь хүн амын массыг дэмжих RRU-ийн физик чадвар юм. Энэхүү баримт бичгийн Х.1.3.2, Х.1.3.3-р зурагт үзүүлсэн шиг бүх гэрлийн холбох хэрэгслийг гудамжинд суурилуулсан гэрлийн баганад байрлуулж болохгүй бөгөөд заримыг нь барилга байгууламж болон бусад хүсээгүй цацаргалт байгууламж, тэдгээрийн хооронд бэхлэх эсвэл өлгөх болно.

Энэхүү баримт бичигт RRU-ийн физик шинж чанарыг тодорхой заагаагүй ч масс нь RRU (ихэвчлэн 5-20 кг жинтэй) нь 2-р шатны мэдрэгчийн хэрэгжилтээс илүү байх болно.

Гэрлийн багана руу шууд тэжээгддэг нийтийн сүлжээнээс цахилгаан тэжээлийн хүртээмж, чанар нь 5G үйлчилгээг үзүүлэхэд хангалттай байх магадлал багатай. Үнэн хэрэгтээ, цахилгаан эрчим хүчний хангамж тасалдсан үед 5G сүлжээний үйлчилгээг хангах нь чухал ач холбогдолтой.



Х.1.3.2-р зураг - Тусдаа кабельд холбогдсон өгөгдөл ба цахилгаан хангамжийн замын схем

Тохиромжтой тэжээлийн болон холболтын бүтцийг хэрэгжүүлэхгүй бол аль нэг цэгийн гэмтэл (жишээлбэл, зам дээрх барилгын ажлын улмаас үүссэн холболт эсвэл цахилгаан дамжуулах шугам) нь олон тооны RRU үйлчилгээний хоцролтод хүргэж болзошгүй.


ТАЙЛБАР: Нөөцгүй шууд тэжээлийн хангамж яагаад хүлээн зөвшөөрөгдөхгүй болохыг дараах байдлаар тайлбарлав.

5G eMBB үйлчилгээний хувьд нийт бэлэн байдал нь "гурван ес" буюу 99.9-ээс их байх шаардлагатай. Энэ нь жилд 31536 секундйн сул зогсолттой тэнцэж байна.

Ийм сул зогсолт нь нэг удаа 526 минутын үйлчилгээний доголдол эсвэл 316 секундйн 100 үе байж болох тул үүнтэй төөрөлдүүлж болзошгүй юм.

Жишээлбэл, хэрэв RRU-ийн тэжээлийн хангамжийн 1 секундйн доголдол нь системийг унтрахад хүргэж болзошгүй бөгөөд RRU-ийн төлөвлөсөн ажиллагааг сэргээх нэмэлт хугацаа хамгийн багадаа 5 минут байсан бол жилд ердөө 105 удаа цахилгааны тасалдал гарах болно. Нийт бэлэн байдал 99.9. Цахилгаан хангамжийн бэлэн байдлыг хамгийн багадаа 99.99997 (өөрөөр хэлбэл "6 ес"-ээс илүү) байхыг шаарддаг.

Автомат жолоодлого зэрэг 5G URLLC үйлчилгээнүүдийн хувьд нийт бэлэн байдал нь "зургаан ес" буюу 99.9999 илүү байх шаардлагатай. Энэ нь жилд 31,5 секундйн сул зогсолттой тэнцэнэ. Хэрэв RRU-д төлөвлөсөн функцээ сэргээх нэмэлт хугацаа хамгийн багадаа 5 минут байсан бол цахилгаан тасрахыг зөвшөөрөхгүй, өөрөөр хэлбэл эрчим хүчний хүртээмж нь 100 хувь байх ёстой. "Цагирган" схем хэрэгжүүлснээр өгөгдөл болон эрчим хүчний хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. 4.13-р зурагт холболтын олон янз байдлыг нэмэгдүүлэх аргыг харуулав. Энэ нь санамсаргүй гэмтлийн улмаас тасалдал үүсэх эрсдэлийг бууруулдаг.



Х.1.3.3-р зураг - Утасгүй өгөгдөл ба кабелийн цахилгаан хангамжийн замын схем

Өгөгдлийн холболт


Зэргэлдээх RRU-уудыг ялгаатай BBU болон олон mmWave антенаар тэжээх боломжтой (Зураг Х.1.3.3). Хоёр шийдлийг аль алиныг Зураг Х.1.3.2-ын холбогдох цагариган бүтцийг ашиглан сайжруулах боломжтой.

Тэжээлийн хангамж

Хэрэгжүүлсэн цахилгаан хангамжаас үл хамааран орон нутгийн хэт ачаалал нь бусад хүсээгүй цацаргалт тоног төхөөрөмжийн цахилгаан хангамжийг

алдагдуулахааргүй байх. Хоёр шийдлийг Зураг Х.1.3.3-т холбогдох цагариган бүтцийг ашиглан сайжруулсан.

RRU-г цахилгаан эрчим хүчээр хангах өөр хувилбаруудын тайлбар: Цахилгаан эрчим хүчний найдвартай байдал, сүлжээгээр хангадаг эрчим хүчний чанар ихэнх тохиолдолд хангалтгүй байхад дараах нөхцөлийг авч үзнэ.




Х.1.3.4-р зураг - Өгөгдөл ба кабелийн цахилгаан хангамжийн замуудын цагариган хэрэгжилтийн схем

- Тасалдалгүй тэжээлийн системд (UPS) суурилсан зайг орон нутагт суурилуулах нь хэмжээ, жин, холбогдох зөвшөөрлийг авахад хүндрэлтэй байх ба үүнтэй холбоотой хулгай, эвдэн сүйтгэх зэрэг эрсдэлтэй;
- Орон нутгийн эрчим хүчний нөөцийн томоохон эд ангиуд, тухайлбал, дизель үүсгүүр зэрэг RRU-д зориулж суурилуулах нь бохирдол, дуу чимээтэй холбоотойгоор олон нийтийн дунд асуудал тулгардаг бөгөөд хулгай, эвдэн сүйтгэх эрсдэлтэй.
- BBU-ийн тухайд, Зураг Х.1.3.2, Зураг Х.1.3.3 -т батлагдсан кластерийн арга нь батарей болон генератор дээр суурилсан UPS-ийг хоёуланг нь ашиглах боломжийг харуулж байгаа бөгөөд хулгай, эвдрэл гэмтлээс хамгаалах боломжтой, жишээлбэл: тэдгээрийг төв оффис эсвэл түүнтэй адилтгах бүтцэд байршуулах.

ХАВСРАЛТ 2**RRU дэд бүтэц**

RRU-ийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд тэжээлийн хувиргагч, чадлын өсгөгч (PA), радио давтамж (RF) нэвтрүүлэгч ба антен (Зураг Х.2.1) хамаарагдана.

Зураг Х.2.1-д өмнөх хэсгийн кабелийн технологийн хэрэгжилтэд оптоэлектроник хувиргагчийг багтаасан болно. мм долгионы технологийн хэрэгжилт нь нэмэлт антен ба мм долгион хувиргагч бүхий оптоэлектрон хувиргагчаар сольсон.



Х.2.1-р зураг - RRU-ийн бүтэц “Front haul”-д оптик шилэн кабель ашигласан

Цахилгаан хангамжийн хувиргагч

Цахилгаан хангамжийн хувиргагч нь оролтын тэжээлийг шаардлагатай электрон хэлхээний хэрэгцээнд тохируулдаг. Үүнд шаардлагатай AC-DC хувьсах гүйдлийн болон DC-AC тогтмол гүйдлийн цахилгаан хувиргагчийг багтаасан бөгөөд индукцийн эсрэг хэт хүчдэлийн хамгаалалттай.

Чадлын өсгүүр (PA)

Чадлын өсгүүр нь опто-электрон хувиргагчаас хүлээн авсан цахилгаан дохиог RF нэвтрүүлэгч руу дамжуулахын өмнө цахилгаан дохиог өсгөдөг. Энэ нь мөн RF нэвтрүүлэгчээс ирж буй дохиог антенаар агаарын интерфэйс рүү дамжуулахаас өмнө өсгөдөг.

RF нэвтрүүлэгч/хүлээн авагч


RF нэвтрүүлэгч нь завсрын давтамжийн ба үндсэн зурвасын интерфэйс болон дараах функцуудаас бүрдэнэ.

- дохионы модуляц/демодуляц;
- хүчдэлийн удирдлагатай осциллятор (VCO) ба холигч;
- тоон аналог хувиргагч;
- аналогийг тоон дохио болгон хувиргах;
- бага шуугианы өсгөгч (өсгөлт, хугацааны синхрончлол).

Х.2.1 RRU суурилуулалт

Энд RRU суурилуулах горим ба гэрлийн баганын дизайны шаардлагыг тодорхойлсон. Энэ нь гэрлийн баганад бэхлэх, механик интерфейс болон хангалттай ачааллын даах чадварыг тодорхойлдог. Х.2.1.1-р зурагт үзүүлсэнчлэн RRU-г дээд талд ба хажуу талд гэсэн суурилуулах горимуудтай. Антену хамрах хүрээг оновчтой болгохын тулд суурилуулах өндөр нь 2.5 м-ээс багагүй байх ба угсралтын аюулгүй байдлын аливаа эрсдэлээс зайлсхийхийн тулд гэрлийн баганын ханын хамгийн бага зузаан нь 4 мм байна.

Төхөөрөмжийг хэт ачааллаас хамгаалахад газардуулгын цахилгаан дамжуулагчаар тухайн газардуулга хийх боломжтой (гэмтэл гарсан үед). Энэ нь аюулгүй байдлын I ангиллын төхөөрөмжид хамаарна. Аюулгүй байдлын II ангиллын хэрэглээ (давхар тусгаарлагч) төхөөрөмж нь ихэвчлэн тухайн байршлын газардуулга хийх шаардлагагүй болгодог. Ойролцоох аянга цахилгаанаас үүссэн индукцийн хэт хүчдэл нь тэжээлийн утас эсвэл арын холболтоор дамжуулан төхөөрөмжид хүрч болно. Иймээс тоног төхөөрөмжийг цаг тухайд нь хамгаалах шаардлагатай. Зардал болон ашиглалтын асуудлаас шалтгаалж сайн (бага эсэргүүцэлтэй) газардуулга байхгүй байж болзошгүй тул тоног төхөөрөмжийг хамгаалах төхөөрөмжийн оролтын хэлхээний хэт хүчдэлийн эсэргүүцлийг нэмэгдүүлэх хамгаалалтын хэлхээг ашиглах зэрэг шийдэл байна. RRU антену хэвийн шугамын хэвтээ чиглэлд $\pm 60^\circ$, босоо чиглэлд $\pm 30^\circ$, антену цацрагийн чиглэлээс 2 м-ийн зайд RRU-д радио хамрах хүрээ сөргөөр нөлөөлөх тул металл хамгаалалтаас зайлсхийх хэрэгтэй. Зарим тохиолдолд техник эдийн засгийн үндэслэлийг үнэлсний дараа шаардлагатай бол хоёр, гурван RRU-г гэрлийн тулгуур дээр суурилуулж болно.



Х.2.1.1-р зураг - RRU-г суурилуулах горим

RRU дээд талын суурилуулалт

RRU-г дээд талд суурилуулсан угсралт нь гэрлийн багана 5G RRU-д холбогдох зориулалттай механик фланц интерфестэй байж болно.

Энэ нь цаг агаарын эрс тэс нөхцөлд гэрлийн баганын аюулгүй байдлыг хангах, салхины ачааллыг хангалттай эсэргүүцэх чадварыг баталгаажуулах ёстой. Сүлжээний байршуулалтын дагуу RRU хамрах хүрээний чиглэлийг өөрчлөхийн тулд 360° хэвтээ эргэлтийн тохируулгыг дэмжинэ.

RRU хажуугийн суурилуулалт

RRU хажуугийн суурилуулалт нь одоо байгаа гэрлийн багана дээр шууд багтах боломжтой. RRU-ийн кабель ба утаснуудыг баганын дотор талд нэвтрүүлэхийн тулд цахилгаан кабель ба оптик утаснуудад ихэвчлэн 20 мм диаметртэй нүхийг

өрөмдөх боломжийн үнэлгээг хийх шаардлагатай. Үгүй бол кабель ба утаснуудыг хоолойн хавчаараар дамжуулан багана дээр гаднаас нь суурилуулж болох боловч ийм шийдэл нь харааны нөлөөлөл, бат бөх чанар багатай тул оновчтой биш байж магадгүй юм. Нэмж дурдахад, RRU-г суурилуулах угсралтын иж бүрдэл нь хамрах хүрээг оновчтой болгохын тулд өнцгийн тохируулга хийх боломжтой.

Хамгаалах ба далдлах хайрцаг

Бүрхүүл нь олон RRU (жишээ нь, нэг чийдэнгийн багана дээр 2 RRU) суурилуулах, RRU-д зарим тохиолдолд модны мөчрөөс үүсэх гаднын механик нөлөөг далдлах, механик хамгаалалт өгөх антенныг хамгаалах зориулалттай. Иймд бүрхэвч нь RRU-д далдлах, механик хамгаалалт өгөх боломжтой. Нуух хайрцгийн загвар нь хүндрэлтэй хүчин зүйлсийг хангах шаардлагаас хамаарч (жишээлбэл, дулаан ялгаруулах, ус үл нэвтрэх, жижиглэсэн хэмжээ) нарийн төвөгтэй байж болно. Иймд боломжтой тохиолдолд RRU-гэрлийн багана дээр шууд суурилуулах нь тохиромжтой байж болох юм. Бүрхүүл нь гэрлийн баганатай уялдаж, RRU-ийн хамрах өнцгийг уян хатан тохируулах боломжийг олгоно. Энэ нь дохионы хамгаалалтаас зайлсхийхийн тулд металл бус материалыг ашиглах ёстой бөгөөд өнгө нь чийдэнгийн баганатай тохирч байх ёстой. Энэ нь дулаан ялгаруулалтыг хангахаар хийгдсэн байх ёстой. Ус үл нэвтрэх загварыг бас анхаарч үзэх хэрэгтэй.

RRU Цахилгаан тэжээлийн хэрэглээ

Олон оролт-олон гаралттай (MIMO) технологийн дэмжлэгтэйгээр гэрлийн багана дээр байрлуулсан RRU-уудын үүсгэсэн бичил үүрийн бодлогоор ердийн эрчим хүчний хэрэглээ нь 100 ваттаас илүү байж болно. Гэрлийн багана дээр байрлуулсан RRU-уудын хэрэгжүүлсэн, ижил MIMO технологи бүхий мини, макро үүрийн ердийн эрчим хүчний хэрэглээ 400 ватт байж болно. Гэсэн хэдий ч энэ нь бүх ерөнхий шаардлага биш бөгөөд MNO-аас RRU-ийн тодорхой хэрэгжилтээс хамаарна. RRU хөгжүүлэлтийн шийдлүүдийн тусламжтайгаар бага эрчим хүчний хэрэглээ нь алсын зайнаас илүү өргөн хүрээг хамардаг эрчим хүчний технологи ба зардлын сонголтуудыг авч үздэг. Ийм эрчим хүчний хэрэглээ нь ямар ч идэвхтэй арга хэмжээ авахгүйгээр цэвэр агаарыг хөргөх боломжийг олгодог. Энэ нь эрчим хүчний хэрэглээ, RRU-ийн хэмжээ, жинг бууруулж, гэрлийн баганын ойролцоо амьдардаг хүмүүсийг бухимдуулах акустик чимээ шуугианаас зайлсхийх болно.

Хувиргагчийн тэжээлийн хангамж

RRU-ийн бүрэлдэхүүн хэсгүүдэд шаардлагатай хүчдэлийн хангахын тулд AC-DC эсвэл DC-DC хүчдэлийн хувиргагч шаардлагатай. Цахилгаан тэжээлийн хувиргагч нь RRU-г аянгын цохилтоос үүдэлтэй аливаа хэт хүчдэлээс хамгаалдаг. Зардал болон ашиглалтын асуудлаас шалтгаалж сайн (бага эсэргүүцэлтэй) газардуулга нь бүх гэрлийн багана дээр байхгүй байж болох тул IV ангиллын хэт хүчдэлийн хувьд хангалттай сайжруулсан тусгаарлалтыг хийхийн тулд цахилгаан тэжээлийн (8-10 кВ ба хосолсон Хэмжилтийн долгион 1.2/50 мкс).

Опто-электрон хувиргуур

Опто-электрон хувиргуур нь дараах шаардлагыг хангадаг.

- Опто-электрон хувиргалт: оптик дохиог цахилгаан дохионд хувиргах
- Цахилгаан оптик хувиргалт: Чадлын өсгүүрээс (PA) цахилгаан дохиог BBU руу дамжуулах оптик дохиог үүсгэх.

Ашигласан технологи, шаардлагатай гаралтын чадал зэрэг оптик дамжуулагчийн үйл ажиллагаанд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлнө.

- Цахилгаан оптик хувиргалт: BBU-д дамжуулахын тулд чадлын өсгүүрээс цахилгаан дохиог оптик дохионд хувиргах.

Оптик нэвтрүүлэгч хүлээн авагчийн үйл ажиллагаанд ашигласан технологи, шаардлагатай гаралтын чадал болон үйл ажиллагааны нөхцөл нөлөөлнө.

Чадлын өсгүүр

Чадлын өсгүүрийн (PA) чадлын хэрэглээг дараах параметрууд дээр үндэслэн загварчилна.

- Нэвтрүүлэх антенаар цацагдаж байгаа гаралтын чадал;
- Чадлын өсгүүрийн (PA) гаралтын чадал;
- антены хамгийн их зурвасын өргөний эзлэх хувь, өөрөөр хэлбэл физик нөөцийн блокуудын бодит тоо.

Чадлын өсгүүрийн (PA) нь чадлын анхдагч хэрэглэгч юм. Ерөнхийдөө чадлын өсгүүрүүд (PA) нь антены нэвтрүүлэх чадлын хүрээнд бага үр ашиг, өндөр давтамжтай байдаг 5G сүлжээний микро үүрийн хэрэглээнд ашиглана.

Антен

Антен нь цэвэр идэвхгүй элемент учраас эрчим хүчний хэрэглээнд шууд нөлөөлөхгүй. Антены шинж чанар (антены өсгөлт ба цацаргалтын диаграм) нь нэвтрүүлэгчийн чадлыг ихэсгэх эсвэл багасгах байдлаар шууд бусаар нөлөөлдөг. Антеныг RRU-д нэгтгэж болно. Олон оролт-олон гаралт (MIMO) технологийг дэмжих тохиолдолд нэмэлт хэрэглээ шаардлагатай болно.

Х.2.2 Цахилгаан тэжээлийн хангамж

Сүлжээнээс авах тэжээл (Power from the grid)

Х.1.3.2 ба Х.1.3.2 -р зургуудад Нэг багц RRU гэмтсэний улмаас үйлчилгээний тасалдал гарахгүй байхаар тусдаа тэжээлийн хангамжийн хувилбаруудыг харуулсан. 5G Утасгүй сүлжээг хялбархан байршуулах зорилготойгоор хөгжүүлснээр 5G-тэй холбоотой үндсэн RRU-ууд ихэвчлэн хувьсах эсвэл тогтмол гүйдлийн тэжээлийг дэмждэг. Ихэнх хөдөлгөөнт сүлжээний операторуудын (MNO) хувьд сүлжээнээс хувьсах гүйдлийн тэжээл авах нь RRU-г тэжээх хамгийн ойлгомжтой бөгөөд энгийн шийдэл болно. Хувьсах гүйдлийн сүлжээнээс гарах чадлыг дэмжих боломжгүй үед өндөр хүртээмжтэй жишээ нь хэт найдваржилттай, бага хоцролтой холбооны (URLLC) үйлчилгээний шаардлагыг хангахын тулд илүү уян хатан тэжээл шаардагдана. Үүнд тэжээлийн нөөцийг нэмэх эсвэл тогтмол гүйдлийн алсын зайн тэжээл зэрэг шийдлүүд байж болох юм.

Гэрлийн баганад суурилуулсан их масстай 5G RRU нь чухал төлөвлөлт, төслийн менежмент шаардана. Учир нь:

- Ийм цахилгаан хангамжийг сүлжээнээс бүх гэрлийн багана хүртэл суурилуулах нь хариуцлагатай томоохон ажил юм.
- Одоо байгаа барилгуудаас цахилгааны сүлжээнд холбогдох, хэдэн зуу, мянгаараа хотын захиргаанаас зөвшөөрөл авах суурилуулах гэж өмчлөгч, түрээслэгч, ханган нийлүүлэгчидтэй хэлэлцээр хийх;
- Гэрлийн баганыг сүлжээнд нэвтрэх хамгийн ойр цэгт холбоход их хэмжээний газар шорооны ухаа ажиллагаа шаардлагатай. Энэ нь замын хөдөлгөөн болон нийт хүн амд саад учруулах, болон өндөр зардал шаардагдана.

Сүлжээ, тоолуур, хамгаалалтын элементүүдийг холбоход зориулж хашлага суурилуулах шаардлагатай бөгөөд бүх тохиолдолд цахилгаан хангамжийн саатлыг дутуу үнэлж болохгүй.

Цахилгаан эрчим хүчний хангамжийн тасралтгүй байдлыг дараах тохиолдлуудад тасалдуулах эрсдэлтэй.

- бусад хүсээгүй цацаргалт гуравдагч этгээдийн техникийн нөлөө;
- аянга цахилгаан (хамгаалалтын унтраалга уналтад хүргэдэг);
- Нийгэм, төрийн үйлчилгээнд хамгийн их хэрэгцээтэй байгаа үед холбооны үйлчилгээнд саад учруулж болзошгүй үер, шуурга зэрэг байгалийн гамшиг

Цаашилбал, сүлжээний цахилгаан хангамж нь ихэвчлэн ноцтой, богино хугацааны тасалдал, тэжээлийн хүчдэлийн өөрчлөлтөд өртдөг. RRU-ийн үйл ажиллагааг тасалдуулах, тэдгээр нь RRU доторх тоног төхөөрөмжийг дахин ачаалах шаардлагын улмаас үйлчилгээний чанарт QoS-д сөргөөр нөлөөлнө. Сүлжээний найдвартай байдал, цахилгаан тэжээлийн чанар нь URLLC үйлчилгээг дэмжиж байгаа үед RRU-д хангалттай байх магадлал багатай юм.

Ийм тохиолдолд хөдөлгөөнт холбооны операторууд тус бүрийг тоног төхөөрөмжөөр хангах замаар асуудлыг шийдэх шаардлагатай болно.

Хотын байршилд гэрлийн баганад байрлах батареинд суурилсан UPS-тэй RRU эсвэл түр алсаас тэжээл өгөх эрчим хүчний шийдэл шаардагдана.

X.2.3 Төвлөрсөн газруудаас авах тогтмол гүйдлийн тэжээл

Сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр хангах

